




БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ 2021-2022



Улаанбаатар хот
2022 он



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

2021-2022

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

АГУУЛГА

- 01 МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР, ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ
- 02 МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН ТҮВШИН
- 03 БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ
- 04 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ
- 05 БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ
- 06 ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ
- 07 БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

Таних тэмдэг:



Ойлголт, тодорхойлолт



Тайлбар



Баримт бичиг



ӨМНӨХ ҮГ

Эрдэм номыг эрхэмлэн дээдлэгч Монгол түмэн, үе үеийн эрдэмтэн, судлаач багш, суралцагчид та бүхэндээ Монгол Улсад орчин цагийн боловсролын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн мэндийг өргөн дэвшүүлье!

Аливаа ажлын үр дүнг хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй гэсэн үг байдаг билээ.

Боловсролын үйлчилгээг бүх түвшинд үр дүнтэй, чанартай, цаг хугацаанд нь хүргэж, ухаалаг, оновчтой шийдвэр гаргахад нарийвчлан боловсруулсан тоон мэдээлэл чухал ач холбогдолтой байдаг.

Ялангуяа төрийн байгууллагуудад төвлөрсөн мэдээллийн сангууд уялдаатай байх нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг цогцоор нь үнэлж дүгнэн нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад чухал үндэслэл болдог.

Иймд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас “Боловсролын салбарын 2021-2022 оны статистикийн эмхэтгэл”-ийг боловсруулан та бүхэнд хүргэж байна. Энэхүү эмхэтгэл нь боловсролын салбарт гарсан өөрчлөлт болон улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилтэд ашиглах боломжтой тоон мэдээллийг үзүүлснээрээ онцлог болсон.

Хэрэглэгч та бүхнийг энэхүү эмхэтгэлийг салбарынхаа бодлого, төлөвлөгөө, арга хэмжээ боловсруулах болон судалгаа, шинжилгээний ажилдаа өргөнөөр ашиглана гэдэгт итгэж байна.

Эрхэм уншигч Та эмхэтгэлийн нүүр хуудаст байрлах QR кодыг уншуулж, эмхэтгэлийг цахим хэлбэрээр татан авах, эсвэл холбоосыг цахим шуудандаа илгээх боломжтой.


УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

МОНГОЛ УЛСЫН


ӨРСӨЛДӨХ ЧАДВАР, ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР, ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ




Эх үүсвэр: УСХ, Хүний хөгжлийн танилцуулга, 2020 он
*Урьдчилсан гүйцэтгэл

Хүний хөгжлийн индекс нь урт удаан, эрүүл амьдарч байгаа байдлыг нь дундаж наслалтаар, мэдлэг эзэмших чадварыг нь суралцсан болон суралцах хугацаагаар, зохистой амьдралын түвшинд хүрэх нөхцлийг нь нэг хүнд ногдох үндэсний орлогоор тооцож буй цогц индекс юм.

 Монгол Улсын хүний хөгжлийн индекс 2020 оны урьдчилсан тооцоогоор 0.774 болж, 2015 оноос 0.019 нэгжээр өссөн байна.

Монгол Улсын хүний хөгжлийн индекс, урьдчилсан гүйцэтгэл, аймаг нийслэлээр, 2020 он



 2020 оны урьдчилсан тооцоогоор аймаг, нийслэлийн хүний хөгжлийн индексийг авч үзэхэд хамгийн өндөр нь Улаанбаатар хот (0.846) болон Орхон аймаг (0.806) байв. Ихэнх аймгуудын хүний хөгжлийн индекс улсын дунджаас доогуур байгаа бөгөөд Улаанбаатар хотын хүний хөгжлийн индекс өндөр байгаа нь нийт хүн амын тал хувь, ДНБ-ий 64.5 хувь үйлдвэрлэгдэж, их, дээд сургууль, коллежийн ихэнх хувь нь байрлаж байгаагаар холбоотой юм.


Эх үүсвэр: УСХ, Хүний хөгжлийн танилцуулга, 2020 он



Хүний хөгжлийн бүрэлдэхүүн индекс болох хүн амын боловсролын түвшний индекс 2015 онд 0.732 байсан бол 2020 онд 0.761 болж 0.029 нэгжээр, дундаж наслалтын индекс 2015 онд 0.768 байсан бол 2020 онд 0.780 болж 0.012 нэгжээр, харин нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын индекс 2015 онд 0.767 байсан бол 2020 онд 0.782 болж 0.015 нэгжээр тус тус өссөн байна.



Хүний хөгжлийн бүрэлдэхүүн индексүүд, 2015-2020 он




● Дундаж наслалтын индекс ● Боловсролын түвшний индекс
● Нэг хүнд ногдох ҮНО-ын индекс

* Урьдчилсан гүйцэтгэл
Эх үүсвэр: ҮСХ, Хүний хөгжлийн тайлан, 2020 он



Боловсролын түвшний индекс, аймгаар 2020 он




Боловсролын индексийг сургуульд суралцсан дундаж хугацаа болон сургуульд суралцах хүлээгдэж буй хугацаагаар тооцдог бөгөөд 2020 онд Улаанбаатар (0.891), Дархан-Уул (0.796) аймгууд улсын дунджаас өндөр байна. Харин Дундговь (0.588), Өвөрхангай (0.593), Сүхбаатар (0.606), Булган (0.608) аймгууд улсын дунджаас доогуур байна.

Сургуульд суралцсан дундаж хугацаа Улаанбаатарт 11.7 жил буюу улсын дунджаас 1.1 жилээр илүү байна.

Сургуульд суралцах хүлээгдэж буй хугацааны үзүүлэлтийн хувьд Улаанбаатарт хамгийн өндөр буюу 18.9 жил байна.

○ Боловсролын индекс
● Сургуульд суралцах хугацаа /жилээр/
● Сургуульд суралцсан дундаж хугацаа /жилээр/

Монгол Улсын өрсөлдөх чадвар, 2018-2021 он



Эх үүсвэр: Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2021 он



Өрсөлдөх чадварыг энгийнээр “Тухайн бүс нутаг (улс, аймаг, дүүрэг) хүмүүсийнхээ сайн сайхан байдлыг дээшлүүлэхийн тулд өөрийн нөөц боломж, чадамжаа хэр ашиглаж, удирдаж буй нь” (IMD Дэлхийн өрсөлдөх чадварын төв, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв) хэмээн ойлгож болно



Монгол Улс 2021 онд өрсөлдөх чадвараар 64 улсаас 60 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

Монгол Улсын авьяас, ур чадварын эрэмбэ, 2018-2021 он



Эх үүсвэр: Дэлхийн авьяас, ур чадварын тайлан, 2021



Монгол Улс 2021 онд авьяас, ур чадварын үнэлгээгээр 64 орноос 61 дүгээрт эрэмбэлэгдсэн байна.

Монгол Улсын дижитал өрсөлдөх чадварын эрэмбэ, 2021 он

Рэнк	Улс	Мэдлэг	Технологи	Ирээдүйд бэлэн байдал
1	АНУ	1	7	2
2	Сингапур	2	1	12
3	Дани	6	9	1
4	Швед	4	6	7
5	Хонг конг	7	2	10
59	Аргентин	50	62	47
60	ӨАБНУ	60	55	57
61	Колумб	59	61	50
62	Монгол	58	60	59
63	Венесуэл	61	63	63

Эх үүсвэр: Дэлхийн дижитал өрсөлдөх чадварын тайлан, 2021




Монгол Улс 2021 онд дижитал өрсөлдөх чадвараар 64 орноос 62 дугаарт эрэмбэлэгдсэн байна.



МОНГОЛ УЛСЫН
ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН ТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН ТҮВШИН¹

Хүн амын бичиг үсгийн түвшин, хувиар, 1921-2020 он



Эх үүсвэр: УЦХ, 2020 он



Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр 15, түүнээс дээш насны хүн амын 98.7 хувь нь бичиг үсэг тайлагдсан байна. Энэ нь 2010 оноос хойш 0.4 пунктээр өссөн. Монгол Улсын бичиг үсэг тайлагдалтын түвшин дэлхийн улс орнуудын дундаж түвшинтэй харьцуулахад өндөр хэвээр байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор боловсролын үзүүлэлтүүд 2010 оны тооллогоос өсөж, харин 10, түүнээс дээш насны хүн амд боловсролгүй хүний эзлэх хувь буурсан байна. Энэ нь манай улсын боловсролын систем улам бүр шинэчлэгдэж, хөгжингүй орнуудын түвшинд хүрч байгааг илэрхийлж байна.



¹Эх үүсвэр: Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого-Нэгдсэн дүнгээс авав.




Хүн амын боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэгийн үр дүнгийн харьцуулалт, 2010, 2020 он

Үзүүлэлт	2010	2020	Өсөлт, бууралт, пункт
10, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хувь			
Боловсролгүй	7.5	4.9	2.6 ↓
Эмэгтэй	6.9	4.6	2.3 ↓
Эрэгтэй	8.0	5.3	2.7 ↓
Боловсролтой	92.5	95.1	2.6 ↑
Эмэгтэй	93.1	95.4	2.3 ↑
Эрэгтэй	92.0	94.7	2.7 ↑
Бага	15.8	13.7	2.1 ↓
Суурь	17.9	17.1	0.8 ↓
Бүрэн дунд	32.0	29.2	2.8 ↓
Техникийн болон мэргэжлийн	2.8	3.9	1.1 ↑
Тусгай мэргэжлийн дунд	5.7	4.7	1.0 ↓
Дээд, түүнээс дээш	18.3	26.5	8.2 ↑
15, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн түвшин, хувь*			
Бичиг үсэг мэддэг	98.3	98.7	0.4 ↑
Бичиг үсэг мэддэггүй	1.7	1.3	0.4 ↓
6-29 насны хүн амын сургуульд хамрагдалт, хувь			
Сургуульд сурдаг	58.1	72.6	14.5 ↑
Сургуульд сурдаггүй	41.9	27.4	14.5 ↓
Хот	60.1	73.7	13.6 ↑
Хөдөө	53.8	70.6	16.8 ↑
Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт, хувь	60.1	84.1	24.0 ↑


Тайлбар: *Монголд суугаа гадаадын харьяат иргэн болон харьяалалгүй иргэн ороогүй. Эх үүсвэр: УСХ-ны “Хүн ам, орон сууцны тооллого 2020”-ын үндсэн үр дүн, 2020 он

Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он




Эх үүсвэр: ҮСХ-ны “Хүн ам, орон сууцны тооллогын үндсэн үр дүн, 2020 он

Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хүйс, хувиар, 2020 он



Эх үүсвэр: ҮСХ-ны “Хүн ам, орон сууцны тооллогын үндсэн үр дүн, 2020 он

 2020 оны тооллогын дүнгээс эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн боловсролын түвшний ялгаа их болсон нь харагдаж байна.

The background features a light green to dark green gradient. A grid of small white dots is visible, with a network of thin white lines connecting some of them, creating a geometric pattern. The overall aesthetic is modern and digital.

БОЛОВСРОЛЫН

САЛБАРЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН БАЙГУУЛЛАГА



Монгол Улсын хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилд 2,389 байгууллага хичээл сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 1,052.3 мянган оюутан, суралцагч суралцаж, 99.4 мянган багш, ажиллагчид ажиллаж байна.



Боловсролын сургалтын байгууллага



- Дээд боловсролын сургалтын байгууллага
- Ерөнхий боловсролын сургууль
- Цэцэрлэг



Бүх шатны боловсролын сургалтын байгууллага 2021-2022 оны хичээлийн жилд 2,389 болж өмнөх оны хичээлийн жилээс 8 (0.3%)-аар өссөн байна.




Боловсролын сургалтын байгууллага, байршил, өмчийн хэлбэрээр




2021-2022 оны хичээлийн жилд төрийн өмчийн нийт сургалтын байгууллага 1,674 болж өмнөх хичээлийн жилээс 34-өөр өссөн бол хувийн өмчийн сургалтын байгууллага 715 болж 26-аар буурсан байна.

Харин хотод байршилтай сургалтын байгууллагын нийт тоо 1,042 болж өмнөх хичээлийн жилээс 1-ээр, хөдөөгийн сургалтын байгууллагын нийт тоо 1,347 болж 7-оор тус тус өссөн байна.




2. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН СУРАЛЦАГЧ, ТӨГСӨГЧ

Боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, байгууллагын ангиллаар, мянган хүн



- Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид
- Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид
- Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид

 Бүх шатны сургуульд суралцагчид 2021-2022 оны хичээлийн жилд 1,052.3 мянгад хүрч, өмнөх оны хичээлийн жилээс 22.7 мянгаар буурсан байна. Нийт суралцагчдын тоо өмнөх оны хичээлийн жилээс буурахад сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид 56.0 мянгаар буурсан нь нөлөөлжээ.



Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын онцгой нөхцөл байдалд хариу арга хэмжээ авч Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан (А/292, А/525) тушаалаар түр журам боловсруулан баталж, 2021-2022 оны хичээлийн жилд 3-5 настай хүүхдийг цэцэрлэгт хамруулсан.

Боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, хүйсээр, мянган хүн

 2021-2022 оны хичээлийн жилд 539.6 мянга нь эмэгтэй, 512.7 мянга нь эрэгтэй суралцагчид байна. Эмэгтэй суралцагчид 2021-2022 оны хичээлийн жилд өмнөх хичээлийн жилээс 10.5 мянгаар, эрэгтэй суралцагчид 12.4 мянгаар тус тус буурсан байна.



Сургалтын байгууллагыг төгсөгчид, хүйсээр, мянган хүн




Бүх шатны сургуулийг 2020-2021 оны хичээлийн жилд 9-р ангийг 44,850 сурагч, 12-р ангийг 34,813 сурагч, их, дээд сургууль, коллежийг 31,161 оюутан тус тус төгсжээ. Нийт төгсөгчдийн 55.3 хувь нь эмэгтэйчүүд байна.

Төгсөгчид ба шинэ элсэгчид

Үзүүлэлт	2019/2020	2020/2021	2021/2022
Ерөнхий боловсролын сургуулийн суурь боловсрол төгсөгчид (нийт)	43,690	45,916	
Ерөнхий боловсролын сургуулийн суурь боловсрол төгсөгчдөөс 10 ангид шинээр элсэгчдийн эзлэх хувь		78.0	79.4
Ерөнхий боловсролын сургуулийн бүрэн дунд боловсрол төгсөгчид (нийт)	29,644	35,850	
Ерөнхий боловсролын сургуулийн бүрэн дунд боловсрол төгсөгчдөөс дээд боловсролын сургалтын байгууллагад элсэгчдийн эзлэх хувь		65.0	70.4


3. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН БАГШ, АЖИЛЛАГЧИД

Нийт багш, ажиллагчид, байгууллагын ангиллаар, мянган хүн



Бүх шатны сургуульд 2021-2022 оны хичээлийн жилд 99.4 мянган багш, ажиллагчид ажиллаж байгаагийн 31.0 мянга нь сургуулийн өмнөх боловсролын байгууллагад, 56.2 мянга нь ерөнхий боловсролын сургуульд, 12.2 мянган нь их, дээд сургууль, коллежид ажиллаж байна.

Нийт багш, ажиллагчид, хүйс, өмчийн хэлбэрээр, мянган хүн



Бүх шатны сургуульд 2021-2022 оны хичээлийн жилд ажиллаж байгаа нийт багш, ажиллагчдын 77.6 мянга нь эмэгтэй, 21.8 мянга нь эрэгтэй байна


Бүх шатны сургуульд ажиллаж байгаа нийт багш, ажиллагчдын 84.5 мянга нь төрийн өмчийн, 14.9 мянга нь хувийн өмчийн сургуульд ажиллаж байна. Төрийн өмчийн сургуулийн нийт багш, ажиллагчид өмнөх оноос 3.0 мянгаар өссөн бол хувийн өмчийн сургуулийн багш, ажиллагчид 0.7 мянгаар буурсан байна.

4. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСӨВ

Боловсрол, шинжлэх ухааны салбарын нийт төсөв, салбараар, тэрбум төгрөг, 2018-2021 он



Эх үүсвэр: БШУЯ-ны Санхүүгийн хэлтсийн дотоод мэдээлэл.

 Боловсрол, шинжлэх ухааны салбарын нийт төсөв 2020 онд 1,738.1 тэрбум төгрөг байсан бол 2021 онд 1,711.6 тэрбум төгрөг болж 1.5 хувиар буурсан байна. Харин салбарын нийт төсөвт боловсролын салбарын төсвийн эзлэх хувь 2020 онд 97.5 хувь байсан бол 2021 онд 95.9 хувь болж 1.6 пунктээр буурчээ.


Боловсрол, шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, сая төгрөгөөр, 2017-2021 он



Эх үүсвэр: БШУЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дотоод мэдээлэл, 2021.06 сар



Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, 2018-2021 он




Эх үүсвэр: БШУЯ-ны Санхүүгийн хэлтсийн дотоод мэдээлэл, 2021.06 сар



Боловсролын салбарын төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2020 онд 4.6 хувь байсан бол 2021 онд 3.9 хувь болж 0.7 пунктээр буурсан байна.



Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн улсын төсвийн орлогод эзлэх хувь 2018-2021 он



Эх үүсвэр: БШУЯ-ны Санхүүгийн хэлтсийн дотоод мэдээлэл,



Боловсролын салбарын төсвийн улсын төсвийн орлогод эзлэх хувь 2020 онд 16.9 хувь байсан бол 2021 онд 18.0 хувь болж 1.1 пунктээр өссөн байна.

Чанар, үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт



Хүүхэд бүрд чанартай боловсролыг тэгш олгох боломжийг бүрдүүлсэн, сургалтын чанар, үр дүнгийн гүйцэтгэлийг урамшуулж, чадварлаг багшийг дэмжсэн, ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжоор хангасан боловсролын санхүүжилтийн цогц шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

**СУРГАЛТЫН ЧАНАРТ
СУУРИЛСАН ЦАЛИН,
УРАМШУУЛЛЫГ ОЛГОХ**



Сурлагын **АХИЦ ДЭВШЛИЙН**
ҮНЭЛГЭЭНИЙ тогтолцоог бий болгоно.
СУРЛАГЫН АМЖИЛТААР багшийн
ажлыг үнэлж, **ТОХИРСОН ЦАЛИН,**
УРАМШУУЛЛЫГ олгоно.

**ЕБС, МСУТ-ИЙГ ХАГАС БИЕ
ДААСАН ТОГТОЛЦООНД
ШИЛЖҮҮЛЭХ**



ХАРИУЦЛАГЫГ САНХҮҮГИЙН ЭРХ
МЭДЭЛТЭЙ НЬ ХАМТ тухайн
байгууллагад нь олгоно. Эцэг эх,
ажилчдын тэгш оролцоог хангасан
ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО бий болгоно.

**ХУВЬСАХ ЗАРДЛЫН
АРГАЧЛАЛЫГ
ШИНЭЧЛЭХ**



БОДИТ ӨРТӨГТ **СУУРИЛСАН**
САНХҮҮЖИЛТ ОЛГОНО.

**СУРГУУЛИЙН БҮТЭЦ,
БАЙРШИЛ, ХЭВ
ШИНЖИЙН ОНОВЧТОЙ
ХУВИЛБАРЫГ ТОГТООХ**



Сумдын сургуулийн бүтэц, хэв шинж,
байршлыг **ДАХИН ЗОХИОН**
БАЙГУУЛНА. Хөрөнгө оруулалтыг
ЗӨВХӨН НЭН ШААРДЛАГАТАЙ
БАЙРШИЛД хийнэ.

Үдийн хоол хөтөлбөр 80.6 тэрбум₮

1500 төгрөг | 1 хүүхдийн өдрийн тариф

ЕБС-ийн 1-5 ангийн хүүхдүүдэд үдийн хоолоор үйлчилнэ.

Боловсролын байгууллагуудын бүтцийг оновчтой тогтоож, засаглалыг сайжруулна

Боловсролын чанарын үнэлгээний бие даасан тогтолцоог сайжруулна.

МСҮТ тэтгэлэг

14.1 мянга | Хамрагдах суралцагчийн тоо

МСҮТ суралцагчдын тэтгэлгийг төгсөхөд нь 1 удаа олгоно.

Боловсролын цахим шилжилт

- Онлайн сургалтын платформ бий болгоно.
- Хичээлийн цахим сан бүрдүүлнэ.
- Сурагч сайн багшийн заасан хичээлийн онлайн контентод хандах боломжтой болно.


Боловсролын салбарын цахим шилжилтийн хүрээнд дээрх болон төрөл бүрийн бусад арга хэмжээг авна.

ДЭЭД БОЛОВСРОЛ

Боловсролын зээлийн сан

Нийт: 78.3 тэрбум₮

- Оюутны хөгжлийн зээл 21.8 тэрбум₮
- Гадаадад суралцагчдын зээл 18.7 тэрбум₮
- Бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, 3 хүүхэд нь 13.5 тэрбум₮
зэрэг суралцдаг өрхийн суралцагчдад олгох сургалтын төлбөрийн тэтгэлэг
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг 4.9 тэрбум₮
- Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг 3.4 тэрбум₮
- Сувилагч мэргэжлээр төрийн өмчийн их дээд 1.9 тэрбум₮
сургуульд суралцагсдын тэтгэлэг
- Засгийн газрын гэрээгээр гадаадаас дотоодод 1.9 тэрбум₮
суралцагчдад олгох тэтгэлэг
- Багш мэргэжлээр төрийн өмчийн их, дээд сургуульд 2.3 тэрбум₮
суралцаж байгаа суралцагчдын болон орон нутагт хийх багшлах дадлагын тэтгэлэг
- Засгийн газрын гэрээгээр гадаадаас дотоодод 0.6 тэрбум₮
суралцагчдад олгох тэтгэлэг
- Бусад 8.4 тэрбум₮



СУРГУУЛИЙН ӨМНӨХ
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ, 2021-2022

Үзүүлэлт	Бүгд	Хот	Хөдөө	Төрийн өмчийн	Хувийн өмчийн
Цэцэрлэгийн тоо	1,453	677	776	972	481
Ердийн	1,446	673	773	969	477
Тусгай	5	3	2	2	3
Сувиллын	2	1	1	1	1
Асрамжийн	-	-	-	-	-
Халамжийн	-	-	-	-	-
Бүлгийн тоо	7,877	3,605	4,272	6,432	1,445
Үндсэн	7,460	3,605	3,855	6,015	1,445
Хувилбарт	417	-	417	417	-
Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид	190,991	86,685	104,306	159,836	31,155
Эмэгтэй	93,362	42,419	50,943	78,090	15,272
Эрэгтэй	97,629	44,266	53,363	81,746	15,883
Цэцэрлэгт	178,444	86,685	91,759	147,289	31,155
Эмэгтэй	87,489	42,419	45,070	72,217	15,272
Эрэгтэй	90,955	44,266	46,689	75,072	15,883
Хувилбарт	12,547	-	12,547	12,547	-
Эмэгтэй	5,873	-	5,873	5,873	-
Эрэгтэй	6,674	-	6,674	6,674	-
Шинээр элсэгчид	53,265	21,080	32,185	40,092	13,173
Эмэгтэй	25,591	10,116	15,475	19,235	6,356
Эрэгтэй	27,674	10,964	16,710	20,857	6,817
Халамжид буй хүүхэд	2,837	1,287	1,550	2,433	404
Эмэгтэй	1,310	594	716	1,125	185
Эрэгтэй	1,527	693	834	1,308	219

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ, 2021-2022

Үзүүлэлт	Бүгд	Хот	Хөдөө	Төрийн өмчийн	Хувийн өмчийн
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	1,065	629	436	782	283
Эмэгтэй	392	221	171	294	98
Эрэгтэй	673	408	265	488	185
Малчдын хүүхэд	25,814	853	24,961	25,095	719
Эмэгтэй	12,540	414	12,126	12,191	349
Эрэгтэй	13,274	439	12,835	12,904	370
Нийт багш, ажиллагчид	30,996	14,026	16,970	26,841	4,155
Эмэгтэй	26,395	12,239	14,156	22,532	3,863
Эрэгтэй	4,601	1,787	2,814	4,309	292
Үндсэн багшийн тоо	8,824	4,150	4,674	7,508	1,316
Эмэгтэй	8,487	3,874	4,613	7,194	1,293
Эрэгтэй	337	276	61	314	23
Туслах багшийн тоо	7,788	3,592	4,196	6,562	1,226
Эмэгтэй	7,778	3,586	4,192	6,558	1,220
Эрэгтэй	10	6	4	4	6
СӨБ-ын хамран сургалтын бохир жин	62.6	60.3	64.6	52.4	10.2
Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт /Улсын дундаж/	24.2	24.0	24.4	24.9	21.6

Тайлбар: Хамран сургалтын бохир жинг ҮСХ-ноос гаргасан 2020 оны жилийн эцсийн суурин хүн амын тоог нас дэвшүүлэн тооцов.

Туслах багшийн тоонд ээлжийн багшийг оруулсан болно.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

1. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА




Монгол Улсын хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилд нийт 1,453 цэцэрлэгт 190,991 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж, 30,996 багш, ажиллагчид ажиллаж байна.



“Хүүхдийн цэцэрлэг” гэж /цаашид “цэцэрлэг” гэх/ хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллагыг хэлнэ.




Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, түүнд хамрагдагчид



2021-2022 оны хичээлийн жилд нийт 1,453 хүүхдийн цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оноос 1 цэцэрлэгээр буурсан байна.



Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, өмчийн хэлбэрээр, байршилаар



Нийт цэцэрлэгийн 972 нь төрийн өмчийн цэцэрлэг (27 нь төмөр замын харьяа хүүхдийн цэцэрлэг), 481 нь хувийн цэцэрлэг байна. Төрийн өмчийн цэцэрлэг нь өмнөх хичээлийн жилээс 24 цэцэрлэгээр өсөж, хувийн өмчийн цэцэрлэг 25 цэцэрлэгээр буурсан байна.

Хот

Хөдөө

Төрийн өмчийн

Хувийн өмчийн


Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, өмчийн хэлбэр, байршлаар



Монгол Улсын хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж байгаа нийт цэцэрлэгийн 34 нь багийн төвд (төрийн-33, хувийн-1), 399 нь сумын төвд (төрийн-386, хувийн-13), 285 нь аймгийн төвд (төрийн-285, хувийн-58), 677 нь нийслэлд (төрийн-268, хувийн-409) байна.

2. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БҮЛГИЙН ТОО

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлэг, сургалтын хэлбэрээр



“Хувилбарт сургалт” гэж үндсэн сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.


2021-2022 оны хичээлийн жилд 7,877 бүлэг хичээллэж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 622-оор буурсан байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлэг, өмчийн хэлбэрээр

Хичээлийн жил	Бүлгийн тоо	Төрийн өмчийн	Үүнээс		Хувийн өмчийн	Үүнээс	
			Үндсэн	Хувилбарт		Үндсэн	Хувилбарт
2018-2019	7,903	6,166	5,441	725	1,737	1,736	1
2019-2020	8,122	6,451	5,774	677	1,671	1,671	-
2020-2021	8,499	6,871	6,240	631	1,628	1,628	-
2021-2022	7,877	6,432	6,015	417	1,445	1,445	-

2021-2022 оны хичээлийн жилд төрийн өмчийн 6,432 бүлгийн 6,015 нь үндсэн сургалтаар, 417 нь хувилбарт сургалтаар хичээллэж байна.

Бүлэг дүүргэлт, улсын хэмжээнд




“Бүлэг дүүргэлт” гэж нэг бүлэгт суралцаж байгаа хүүхдийн дундаж тоог хэлнэ.

Улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлэг дүүргэлт дунджаар 24.2 байгаа нь Ковид-19 цар тахлын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг цахимд шилжүүлэн, 4-5 настай хүүхдийг үндсэн сургалтад, 3 настай хүүхдийн хөгжлийг гэр бүлд түшиглэн зайны хэлбэрээр дэмжин ажиллаж, нэг бүлэгт 25-аас олонгүй хүүхэд хичээллүүлэх хариу арга хэмжээ авч ажиллаж байгаатай холбоотой юм.



Бүлэг дүүргэлт, анги, өмчийн хэлбэр, байршил, сургалтын хэлбэрээр



Улсын хэмжээнд цэцэрлэгийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 23.9 байна. Төрийн өмчийн цэцэрлэгийн бүлэг дүүргэлт 24.9 байгаа нь хувийн өмчийн цэцэрлэгийн бүлэг дүүргэлтээс 3.3-аар дээгүүр байна.

3. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЖ БУЙ ХҮҮХДИЙН ТОО



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж буй хүүхэд, өмчийн хэлбэр, сургалтын хэлбэрээр

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Үүнээс		Төрийн өмчийн цэцэрлэгт	Үүнээс		Хувийн өмчийн цэцэрлэгт	Үүнээс	
		Үндсэн сургалт	Хувилбарт сургалт		Үндсэн сургалт	Хувилбарт сургалт		Үндсэн сургалт	Хувилбарт сургалт
2018-2019	261,354	239,764	21,590	222,150	200,579	21,574	39,204	39,185	16
2019-2020	263,333	242,623	20,710	224,975	204,265	20,710	38,358	38,358	-
2020-2021	247,040	229,899	17,141	211,748	194,607	17,141	35,292	35,292	-
2021-2022	190,991	178,444	12,547	159,826	147289	12,547	31,155	31,155	-



СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхдийн тоо 2020-2021 оны хичээлийн жилд 247.0 мянга байсан бол 2021-2022 оны хичээлийн жилд 191.0 мянга болж, 56.0 мянгаар буурсан нь Ковид-19 цар тахлын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг цахимд шилжүүлэн, 4-5 настай хүүхдийг үндсэн сургалтад, 3 настай хүүхдийн хөгжлийг гэр бүлд түшиглэн зайны хэлбэрээр дэмжин ажиллаж байгаатай холбоотой юм.



БШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан А/292, А/525 тоот тушаалаар түр журам боловсруулан баталсан.

СӨБ-д хамрагдсан хүүхдүүдийн 12.5 мянга (6.6%) нь хувилбарт сургалтад хамрагдаж байгаа нь өмнөх хичээлийн жилээс 4.6 (26.8%) мянгаар буурсан байна.


Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан нийт хүүхдүүдийн 159.8 (83.7%) мянга нь төрийн өмчийн, 31.2 (16.3%) мянга нь хувийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байна.

Төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн 92.2 хувь нь үндсэн сургалтад, 7.8 хувь нь хувилбарт сургалтад хамрагдаж байгаа бол хувийн өмчийн цэцэрлэг зөвхөн үндсэн сургалтаар үйл ажиллагаа явуулж байна.





Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж буй хүүхэд, бүлгээр



Цэцэрлэгийн үндсэн сургалтад 2021-2022 оны хичээлийн жилд хамрагдаж байгаа хүүхдийг бүлгээр нь авч үзвэл, бага бүлэгт 7,221 (4.0%), дунд бүлэгт 40,676 (22.8%), ахлах бүлэгт 60,449 (33.9%), бэлтгэл бүлэгт 67,496 (37.8%), холимог бүлэгт 2,602 (1.5%) нь хамрагдаж байна.

Хувилбарт сургалт



“Ээлжийн бүлгийн сургалт” боловсролын стандартыг баримтлан танхимын хэлбэрээр хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.

“Нүүдлийн бүлгийн сургалт” боловсролын стандартыг баримтлан гэр бүлд хүүхдэд үйлчлэх сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.

“Явуулын багшийн сургалт” боловсролын стандартыг баримтлан гэр бүлд түшиглэж, хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.



Хувилбарт сургалтанд хамрагдаж байгаа хүүхдүүдийн 1,456 нь ээлжийн бүлэгт, 8,026 хүүхэд нүүдлийн бүлэгт, 3,065 хүүхэд явуулын багшийн үйлчилгээгээр дамжуулан сургуулийн өмнөх боловсролыг эзэмшиж байна.

5 НАСТАЙ ХҮҮХДИЙН ХАМРАГДАЛТ

5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт




5 настай хүүхдийн хамран сургалтын цэвэр жин 2021-2022 оны хичээлийн жилд 91.3 байгаа нь өмнөх хичээлийн жилээс 0.8 пунктээр буурсан байна.

Тайлбар: 2020 оны 5 настай хүүхдийн тоог МУ-ын 2020 оны суурин хүн амын тоог нас дэвшүүлэн тооцож гаргасан.




Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан 5 настай хүүхдийн тоо, сургалтын хэлбэрээр



2021-2022 оны хичээлийн жилд 5 настай нийт 71,015 хүүхэд хамрагдаж байгаагийн 68,174 (96.0%) нь үндсэн сургалтаар, 2,841 (4.0%) нь хувилбарт сургалтаар сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна.




Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан 5 настай хүүхдийн хамран сургалт, аймгаар



СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ХАМРАН СУРГАЛТ



Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин



Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин 2021-2022 оны хичээлийн жилд 62.2 хувь буюу өмнөх оноос 17.0 пунктээр буурсан байна.

Энэ нь дэлхий нийтэд үүссэн Ковид-19 халдварт цар тахлаас сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдлын үед 3 настай хүүхдийг зайны сургалтаар, 4-5 настай хүүхдийг танхимын сургалтад хамруулахаар түр журмаар зохицуулалт хийсэнтэй холбоотой юм.




БШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан А/292, А/525 тоот тушаалаар түр журам баталсан.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДСАН МАЛЧДЫН БОЛОН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД




Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан малчдын болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд



Сургуулийн өмнөх боловсролд 2021-2022 оны хичээлийн жилд хамрагдсан нийт хүүхдийн 25,814 (13.5%) нь малчдын хүүхэд, 1,065 (0.6%) нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.



Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бэрхшээлийн төрлөөр, 2021-2022 оны хичээлийн жил



2021-2022 оны хичээлийн жилд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамгийн их нь буюу 292 (27.4%) нь хөдөлгөөний бэрхшээлтэй байгаа бол хамгийн бага нь буюу 27 (2.5%) нь оюуны бэрхшээлтэй байна.



- Харааны
- Ярианы
- Сонсголын
- Хөдөлгөөний
- Сэтгэцийн
- Оюуны
- Аутизм
- Дауны хам шинж
- Хавсарсан

4. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ - ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 4.2.1




ТХЗ 4.2.1-д заасан шалгуурыг “Бага насны хүүхдийн хөгжлийн индекс”-ээр дараах үзүүлэлтийн хүрээнд хэмжих юм. 3-4 насны хүүхдийн хөгжлийн дөрвөн айн хүрээнд дараах 10 асуулгаар хөгжлийн явцыг үнэлсэн. Үүнд:


- **Цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадамж:** Цагаан толгойн үсгээс хамгийн багадаа 10 үсэг таньдаг/нэрлэж чаддаг, наад зах нь дөрвөн энгийн түгээмэл үг уншиж чаддаг, 1-10 хүртэлх цифрийг нэрлэж, таньж чаддаг эсэхээр хүүхэд хөгжлийн зохих түвшинд байгааг үнэлдэг. Хэрэв хүүхэд эдгээрээс наад зах нь хоёрыг хийж чадаж байвал тус чадамж нь зохих түвшиндээ байна гэж үзсэн.
- **Бие бялдрын хөгжил:** Хүүхэд хоёр хуруугаараа нарийн саваа, жижиг чулуу гэх мэт зүйлсийг газраас авч чаддаг, эх/асран хамгаалагч нь хүүхдээ заримдаа тоглохоос дургүйцэж, бие нь тавгүйрхэж сурддаггүй гэж хариулсан тохиолдолд тухайн хүүхдийн бие бялдрын хөгжил нь зохих түвшиндээ байна гэж үзсэн.
- **Нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадамж:** Хэрэв хүүхэд бусад хүүхдүүдтэй эвтэй найртай харилцдаг, бусад хүүхдийг өшиглөж, хазаж, цохидоггүй, анхаарал нь өөр юманд амархан сарнидаггүй бол нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадамж нь зохих түвшиндээ байна гэж үзсэн.
- **Суралцах чадамж:** Хүүхэд энгийн зааврын дагуу ямар нэгэн зүйлийг зөв хийж, мөн хийлгэх гэж өгсөн зүйлийг зөв бөгөөд бие даан хийж, гүйцэтгэж байвал суралцах чадамж нь зохих түвшиндээ байна гэж үзсэн.

Эх үүсвэр: ҮСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он

Бага насны хүүхдийн хөгжлийн индекс, ТХЗ 4.2.1



Бага насны хүүхдийн хөгжлийн индекс (МУ-ын тодорхойлолтоор)




Монгол Улсын сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрт цагаан толгойн үсэг нэрлэх, энгийн үгсийг унших зэрэг чадварыг багтаадаггүй тул өөрийн улс орны онцлогийг тусгасан зарим асуултыг асуулгад нэмж оруулж тооцсон.



Бага насны хүүхдийн хөгжлийн индекс 2010 оноос хойш буурах хандлагатай байна.




Бага насны хүүхдийн хөгжлийн индекс, хөгжлийн чадварууд нь зохих түвшинд байгаа 3-4 настай хүүхдийн хувь, үнэлгээний үзүүлэлтээр, СӨБ-д хамрагдсан байдлаар, 2018 он



Эх үүсвэр: ҮСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он



Бага насны хүүхдийн хөгжлийн индекс, хөгжлийн чадварууд нь зохих түвшинд байгаа 3-4 настай хүүхдийн хувь, үнэлгээний үзүүлэлт, хүйсээр, 2018




Эх үүсвэр: УСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он

5. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ, АЖИЛЛАГЧИД



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ажиллагчид, өмчийн хэлбэрээр



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 2021-2022 оны хичээлийн жилд нийт 30,996 багш, ажиллагчид ажиллаж байгаа нь өмнөх хичээлийн жилээс 328-аар өссөн байна.

Нийт ажиллагчдын 26,841 (86.6%) нь төрийн, 4,155 (13.4%) нь хувийн өмчийн цэцэрлэгт ажиллаж байна.

Төрийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ажиллагчид, байршлаар



2021-2022 оны хичээлийн жилд төрийн өмчийн цэцэрлэгт ажиллагчдын 10,608 (39.5%) нь хотод, 16,233 (60.5%) нь хөдөө, орон нутагт ажиллаж байна.

■ Хот ■ Хөдөө ● Төрийн өмчийн цэцэрлэгт ажиллагчид

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа, үндсэн болон туслах багшийн тоо

Хичээлийн жил	Үндсэн багш	Үүнээс:							Туслах багш
		Булгийн	Дуу хөгжмийн	Биеийн тамирын	Тусгай мэргэжлийн	Ээлжийн булгийн	Нүүдлийн	Явуулын	
2018-2019	7,843	6,929	663	159	7	33	21	31	6,673
2019-2020	8,068	7,102	709	189	-	20	25	23	6,870
2020-2021	8,827	7,741	755	266	-	15	21	29	7,819
2021-2022	8,824	7,644	784	315	-	15	27	39	7,788

Улсын хэмжээнд 30,996 багш, ажиллагчид ажиллаж байгаагаас 8,824 (28.5%) нь үндсэн багш байгаа нь өмнөх оноос 0.03 пунктээр буурсан оноос 3-аар буурсан байна

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа үндсэн багшийн боловсролын түвшин

Хичээлийн жил	Мэргэжлийн багшийн хангалт	Үүнээс:				
		Доктор	Магистр	Бакалавр	Диплом	Бусад
2018-2019	91.7	-	532	6,008	650	653
2019-2020	91.1	-	549	6,182	621	716
2020-2021	94.3	2	626	7,108	588	503
2021-2022	97.2	-	794	7,240	545	245

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын мэргэжлийн багшийн хангалт 97.2 хувь болсон нь өмнөх оноос 2.9 пунктээр өссөн байна.




Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа үндсэн багшийн насны бүлэг, ажилласан жил

Үзүүлэлт	2018/2019	2019/2020	2020/2021	2021/2022
Үндсэн багш	7,843	8,068	8,827	8,824
Насны бүлгээр				
30 нас хүртэл	2,209	2,149	2,296	2,160
30-39 нас	2,464	2,640	2,921	3,013
40-49 нас	2,291	2,302	2,469	2,401
50-59 нас	803	894	1,039	1,149
60, түүнээс дээш	76	83	102	101
Ажилласан жилээр				
1 жил хүртэл	1,410	1,247	1,279	768
1-5 жил	3,798	4,019	4,522	4,480
6-10 жил	1,204	1,289	1,401	1,728
11-15 жил	609	678	747	853
16-20 жил	289	316	361	429
21-25 жил	150	140	126	170
26, түүнээс дээш	383	379	391	396



СӨБ-ын нэг багшид ногдох хүүхдийн тоо, аймаг, нийслэлээр



Сургуулийн өмнөх боловсролын нэг үндсэн багшид 21.6 хүүхэд ногдож байна. Харин нэг багшид ногдох хүүхдийн тоогоор Говьсүмбэр (28.9), Төв аймаг (28.1) хамгийн их байгаа бол Дорноговь аймагт хамгийн бага (16.1) байна.


6.ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ



Хүүхдийн амьдралын эхний жилүүдэд тархи нь маш хурдацтай хөгждөг бөгөөд энэ үед гэр орных нь нөхцөл, асран хамгаалагчдын зүгээс хүүхэдтэй хэрхэн харьцаж, хайр халамж тавьж байгаа нь тэдний хөгжилд нөлөөлөх гол хүчин зүйл болдог. Төрсөн цагаас нь хүүхдэд үзүүлэх асаргаа халамж сайн байх нь тэдний хөгжилд чухал үүрэгтэй бөгөөд хүүхэдтэй ярьж, халамжлах нь танин мэдэхүй, бие махбодь, нийгмийн болон сэтгэл зүйн хөгжлийг дэмжиж өгдөг. Энэ утгаараа насанд хүрэгчид хүүхэдтэйгээ хэр их ярьж, харилцаж, тоглодог, гэрт нь хүүхдийн ном, тоглоом бий эсэх, хүүхдэд үзүүлэх халамж асаргаа ямар байдаг зэрэг нь чухал үзүүлэлтүүд юм.




Сүүлийн 3 хоногт гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн зүгээс аливааг танин мэдэх, сурахад нь 4, түүнээс олон дэмжлэг үзүүлсэн 2-4 настай хүүхдийн хувь, 2018 он



Эх үүсвэр: УСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он



Сүүлийн 3 хоногт эцэг, эхийн зүгээс аливааг танин мэдэх, сурахад нь дэмжлэг үзүүлсэн 2-4 настай хүүхдийн хувь, 2018 он




Эх үүсвэр: УСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он



Багаас нь ном үзүүлж, уншиж өгөх нь хүүхдийг номтой эрт танилцуулаад зогсохгүй, ах эгчийгээ хичээлээ хийхийг харах гэх мэтээр бусад хүмүүс хэрхэн уншиж байгааг харах боломж олгодог. Номтой ойр байлгах нь хожим суралцах чадварт нь чухал нөлөө үзүүлдэг.




Номтой 5 хүртэлх насны хүүхдийн хувь, номын тоогоор, байршлаар, 2018 он



Эх үүсвэр: ҮСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он



2 түүнээс олон төрлийн тоглох зүйлтэй 5 хүртэлх насны хүүхдийн хувь, байршлаар, 2018 он



Эх үүсвэр: ҮСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он

7.ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



Сургуулийн өмнөх боловсролын нийт урсгал төсөв, тэрбум төгрөг




Боловсрол, шинжлэх ухааны салбарын 1.3 их наяд урсгал төсвийн 429.5 тэрбум төгрөг буюу 31.2% нь сургуулийн өмнөх боловсролын салбарт зарцуулагдаж байна.

- Боловсрол, шинжлэх ухааны салбарын нийт урсгал төсөв
- Сургуулийн өмнөх боловсролын нийт урсгал төсөв

Эх үүсвэр: БШУЯ-ны Санхүүгийн хэлтсийн дотоод мэдээлэл, 2021.06 сар



Боловсрол, шинжлэх ухааны салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017-2021 онуудад аймаг, нийслэлд хэрэгжүүлсэн цэцэрлэгийн төсөл, арга хэмжээ, тоогоор



- Ашиглалтад орсон цэцэрлэг
- Баригдаж байгаа цэцэрлэг

Эх үүсвэр: БШУЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дотоод мэдээлэл, 2021.06 сар

The background is a gradient of purple, transitioning from a lighter shade at the top to a darker shade at the bottom. It features a grid of small white dots that becomes more prominent towards the top. In the lower half, there are overlapping, semi-transparent geometric shapes, primarily triangles and polygons, in various shades of purple, creating a complex, layered effect.

БАГА, ДУНД

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ, 2021-2022

Үзүүлэлт	Бүгд	Хот	Хөдөө	Төрийн өмчийн	Хувийн өмчийн
Сургууль	848	285	563	682	166
Ердийн	741	217	524	627	114
Төрөлжсөн	16	6	10	14	2
Гүнзгийрүүлсэн	73	45	28	31	42
Тусгай	6	6	-	6	-
Олон улсын хөтөлбөрийн сургалттай	12	11	1	4	8
3 ээлжтэй сургуулийн тоо	4	-	4	4	-
3 дугаар ээлжинд хичээллэдэг бүлэг	13	-	13	13	-
3 дугаар ээлжинд хичээллэж буй суралцагчид	460	-	460	460	-
Бага анги	418	-	418	418	-
Дунд анги	-	-	-	-	-
Ахлах анги	42	-	42	42	-
Бүлгийн тоо	23,835	10,268	13,567	21,181	2,654
Бага анги	11,612	5,092	6,520	10,325	1,287
Дунд анги	8,164	3,472	4,692	7,325	839
Ахлах анги	4,059	1,704	2,355	3,531	528
Суралцагчид	717,451	341,191	376,260	663,697	53,754
Эмэгтэй	356,471	169,411	187,060	330,080	26,391
Эрэгтэй	360,980	171,780	189,200	333,617	27,363
Суралцагч /өдөр/	712,353	340,346	372,007	658,634	53,719
Эмэгтэй	355,170	169,136	186,034	328,783	26,387
Эрэгтэй	357,183	171,210	185,973	329,851	27,332
Суралцагч /орой, эчнээ/	135	-	135	135	-
Эмэгтэй	65	-	65	65	-
Эрэгтэй	70	-	70	70	-
Дүйцсэн хөтөлбөрөөр суралцагч	4,963	845	4,118	4,928	35
Эмэгтэй	1,236	275	961	1,232	4
Эрэгтэй	3,727	570	3,157	3,696	31
Нэгдүгээр ангид шинээр элсэгч	75,518	37,532	37,986	69,527	5,991
Эмэгтэй	37,069	18,333	18,736	34,103	2,966
Эрэгтэй	38,449	19,199	19,250	35,424	3,025
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	5,606	2,635	2,971	5,552	54
Эмэгтэй	2,373	1,047	1,326	2,362	11
Эрэгтэй	3,233	1,588	1,645	3,190	43

БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ, 2021-2022

Үзүүлэлт	Бүгд	Хот	Хөдөө	Гөрийн омчийн	Хувийн омчийн
Малчдын хүүхэд	128,228	7,993	120,235	127,463	765
Эмэгтэй	64,756	4,171	60,585	64,416	340
Эрэгтэй	63,472	3,822	59,650	63,047	425
Дотуур байртай сургуулийн тоо	415	14	401	403	12
Дотуур байрны тоо	548	19	529	535	13
Дотуур байранд амьдарч буй хүүхэд	32,576	1,359	31,217	31,772	804
Эмэгтэй	16,752	571	16,181	16,411	341
Эрэгтэй	15,824	788	15,036	15,361	463
Нийт багш, ажиллагчид	56,228	22,229	33,999	50,038	6,190
Эмэгтэй	43,530	17,620	25,910	38,788	4,742
Эрэгтэй	12,698	4,609	8,089	11,250	1,448
Үндсэн багшийн тоо	35,110	15,504	19,606	31,156	3,954
Эмэгтэй	28,642	12,843	15,799	25,526	3,116
Эрэгтэй	6,468	2,661	3,807	5,630	838
Бага боловсролын хамран сургалтын бохир жин	97.0	98.3	95.8	90.0	7.0
Дунд ангийн хамран сургалтын бохир жин	96.3	99.8	93.4	89.5	6.8



БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

1. БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА



Улсын хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилд нийт 848 ерөнхий боловсролын сургуулийн 23.8 мянган бүлэгт 712.3 мянган суралцагчид (өдрөөр) суралцаж, нийт 56.2 мянган багш, ажиллагчид ажиллаж байна.



Ерөнхий боловсролын сургуулийн тоо, өмчийн хэлбэрээр



Ерөнхий боловсролын 848 сургуулийн 682 (80.4%) нь төрийн өмчийн, 166 (19.6%) нь хувийн өмчийн сургууль байна.

● Нийт сургуулийн тоо ■ Төрийн өмчийн ■ Хувийн өмчийн



Ерөнхий боловсролын сургуулийн тоо, ангиллаар


Хичээлийн жил	Ерөнхий боловсролын сургууль				
	Бүгд	Бага	Дунд	Ахлах	Цогцолбор
2018-2019	803	80	115	563	45
2019-2020	820	78	113	584	45
2020-2021	839	72	109	611	47
2021-2022	848	72	109	622	45



Нийт сургуулийн 72 нь бага сургууль, 109 нь дунд сургууль, 622 нь ахлах сургууль, 45 нь цогцолбор сургуулийн ангилалд багтаж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад ахлах сургуулийн тоо 11-ээр нэмэгдэж, цогцолбор сургуулийн тоо 2-оор буурсан байна.




Ерөнхий боловсролын сургуулийн тоо, ангиллаар



Төрийн өмчийн сургуулиудын 52 нь бага сургууль, 108 нь дунд сургууль, 482 нь ахлах сургууль, 40 нь цогцолбор сургууль байна. Харин хувийн өмчийн сургуулиудын 20 нь бага сургууль, 1 нь дунд сургууль, 140 нь ахлах сургууль, 5 нь цогцолбор сургууль байна.

■ Төрийн өмчийн ■ Хувийн өмчийн

Ерөнхий боловсролын сургуулийн тоо, байршил, хэв шинжээр




Нийт 848 сургуулийн 563 нь хөдөөд, 285 нь нийслэлд байгаа бол 741 нь ердийн, 16 нь мэргэжлийн, 73 нь гүнзгийрүүлсэн, 6 нь тусгай, 12 нь олон улсын хөтөлбөрөөр сургалт явуулж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн тоо, байршил, өмчийн хэлбэрээр, 2021-2022 оны хичээлийн жил

Байршил	Улсын хэмжээнд				Төрийн өмчийн			
	Бүгд	Бага сургууль	Дунд сургууль	Ахлах сургууль	Бүгд	Бага сургууль	Дунд сургууль	Ахлах сургууль
Баг	45	30	8	7	45	30	8	7
Сум	344	7	96	241	339	4	96	239
Аймаг	174	8	1	165	143	5	1	137
Нийслэл	285	27	4	254	155	13	3	139
Нийт	848	72	109	667	682	52	108	522

Ерөнхий боловсролын сургуулийн тоо, хичээллэж байгаа ээлжээр



Нийт 848 сургуулийн 360 (42.4%) нь 1 ээлжээр, 484 (57.1%) нь 2 ээлжээр, 4 (0.5%) нь 3 ээлжээр хичээллэж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн тоо, байршил, ангиллаар




Ерөнхий боловсролын сургуулийг байршлаар авч үзвэл, орон нутагт байгаа ахлах болон бага сургуулийн тоо нийслэлийнхээс 1.6-1.7 дахин их байгаа бол нийслэлд 4 сургууль 9 жилийн боловсрол олгож байна.

Ерөнхий боловсролын сургуулийн тоо, аймгаар


	Багийн төв	Сумын төв	Аймгийн төв
Говьсүмбэр		2	3
Орхон		1	24
Дархан-Уул	1	4	20
Хэнтий	5	18	4
Хөвсгөл	3	23	9
Ховд		17	8
Увс	3	19	8
Төв	1	26	4
Сэлэнгэ		28	7
Сүхбаатар		12	4
Өмнөговь		16	6
Өвөрхангай	3	22	6
Завхан		24	6
Дундговь		14	5
Дорнод	1	13	13
Дорноговь	1	16	4
Говь-Алтай	3	19	6
Булган	2	16	4
Баянхонгор	3	20	10
Баян-өлгий	13	16	15
Архангай	6	18	8



Ерөнхий боловсролын сургууль, суралцагчийн тооны тархалт




100 ба түүнээс доош хүүхэдтэй сургуулийн тоо, байршлаар



2.ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БҮЛЭГ

Ерөнхий боловсролын сургуулийн бүлэг, өдрийн анги, ээлжээр



2021-2022 оны хичээлийн жилд нийт бүлгийн тоо 23,835 болж, өмнөх оны хичээлийн жилээс 856 (3.7%) (үүнээс: бага анги 3.7%, дунд анги 5.4%, ахлах анги 0.6%-иар тус тус өссөн) бүлгээр өссөн байна. 2021-2022 оны хичээлийн жилд нийт бүлгийн 48.7 %-ийг бага, 34.3%-ийг дунд, 17.0%-ийг ахлах ангийн бүлэг эзэлж байна.



Ерөнхий боловсролын сургуулийн нийт бүлгийн 71.6% нь нэгдүгээр ээлжид, 28.3% нь хоёрдугаар ээлжид, 0.1% нь гуравдугаар ээлжид хичээллэж байна.



Ерөнхий боловсролын сургуулийн 3-р ээлжид хичээллэж байгаа бүлэг, хүүхдийн тоо, ангиар

Хичээлийн жил	Бүгд	Бүлгийн тоо			Хүүхдийн тоо			
		Бага	Дунд	Ахлах	Бүгд	Бага	Дунд	Ахлах
2018-2019	212	181	25	6	8,451	7,511	786	154
2019-2020	9	4	3	2	308	150	115	43
2020-2021	8	6		2	251	211	-	40
2021-2022	13	11	0	2	460	418	-	42



Улсын хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилд 4 сургуулийн 13 бүлэгт 460 суралцагч 3-р ээлжид хичээллэж байна. Эдгээр 3-р ээлжийн бүлгийн 90.9 хувь нь бага ангийн, 9.1 хувь нь ахлах ангийн бүлэг байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 3-р ээлжид хичээллэж байгаа бүлэг, хүүхдийн тоо, байршлаар

Он	2018-2019			2019-2020			2020-2021			2021-2022		
	Бүгд	Байршил		Бүгд	Байршил		Бүгд	Байршил		Бүгд	Байршил	
		Хот	Хөдөө		Хот	Хөдөө		Хот	Хөдөө		Хот	Хөдөө
Сургуулийн тоо	28	23	5	2	1	1	4	-	4	4	-	4
Бүлэг	212	188	24	9	7	2	8	-	8	13	-	13
Хүүхдийн тоо	8,451	7,743	708	308	265	43	251	-	251	460	-	460




2021-2022 оны хичээлийн жилд 3 ээлжээр хичээллэж байгаа 4 сургууль бүгд хөдөө аймагт үйл ажиллагаа явуулж байна.

Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын Хантайшир-эрдэм цогцолбор сургууль
 Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын лаборатори хоёрдугаар сургууль
 Дархан-Уул аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын 9 дүгээр сургууль
 Дархан-Уул аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын арван тавдугаар сургууль



“Бүлэг дүүргэлт” нэг бүлэгт суралцаж байгаа хүүхдийн дундаж тоог хэлнэ


Бүлэг дүүргэлт



Улсын хэмжээнд бүлэг дүүргэлт хэвийн байгаа хэдий ч байршил болон өмчийн хувьд ялгаатай, тэр дундаа хотын төрийн өмчийн сургуулийн бүлэг дүүргэлт нормативаас дээгүүр байна.


Бага боловсролын бүлэг дүүргэлт 32.0 байгаа нь өмнөх хичээлийн жилээс 0.1-ээр нэмэгдсэн бол суурь боловсролын бүлэг дүүргэлт 29.2 болж өмнөх хичээлийн жилээс 0.5-аар буурсан байна.

Бүлэг дүүргэлт, өмчийн хэлбэрээр



Төрийн өмчийн сургуульд бүлэг дүүргэлт 31.1 байгаа нь хувийн өмчийн сургуулиас 10.9-өөр их байна.

Бүлэг дүүргэлт, аймгаар



Бүлэг дүүргэлт, дүүргээр



Бүлэг дүүргэлт Улаанбаатар хотод (33.2) хамгийн их, Говь-Алтай аймагт (21.8) хамгийн бага байна.

Дүүргээр авч үзвэл, Сонгинохайрхан дүүрэгт (35.4) хамгийн өндөр, Багахангай дүүрэгт (25.0) хамгийн бага байна.



Бүлэг дүүргэлт норматив хэмжээнээс хэт их (нэг ангид 45 ба түүнээс дээш бүлэг дүүргэлттэй) ерөнхий боловсролын сургуулиуд

Д/д	Дүүрэг	Сургуулийн нэр	Бүлэг дүүргэлт	
			2020-2021	2021-2022
1	Баянгол	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори хорь дугаар сургууль	43.5	45.1 ↑
2	Баянзүрх	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори арван дөрөвдүгээр сургууль	45.8	45.6 ↓
3		Нийслэлийн ерөнхий боловсролын наян дөрөвдүгээр сургууль	47.4	47.0 ↓
4	Сүхбаатар	Нийслэлийн ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль	51.1	51.1
5		Нийслэлийн ерөнхий боловсролын гуравдугаар сургууль	47.1	46.4 ↓
6		Нийслэлийн ерөнхий боловсролын гучин нэгдүгээр сургууль	45.0	45.0
7	Хан-Уул	Нийслэлийн ерөнхий боловсролын арван найм дугаар сургууль	51.7	49.1 ↓
8		Нийслэлийн ерөнхий боловсролын тавин хоёр дугаар сургууль	47.4	47.8 ↑
9		Нийслэлийн ерөнхий боловсролын нэг зуун арван найм дугаар сургууль	43.0	46.0 ↑
10	Чингэлтэй	Нийслэлийн ерөнхий боловсролын тавдугаар сургууль	45.8	46.3 ↑
11		Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори хорин гуравдугаар сургууль	52.6	53.6 ↑



Хэт их буюу 45 ба түүнээс дээш бүлэг дүүргэлттэй сургуулиудын хувьд өмнөх хичээлийн жилээс 5 сургуулийн бүлэг дүүргэлт өссөн, 4 сургуулийн бүлэг дүүргэлт буурсан байгаа бол 2 сургууль хэвээр байна.



Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 307/91/237 тоот тушаалын хавсралтад анги дүүргэлтийг бага ангид 30-35 хүүхэдтэй, дунд, ахлах ангид 32-35 хүүхэдтэй байх нормативыг баталсан.



Бүлэг дүүргэлт норматив хэмжээнээс хэтэрсэн ерөнхий боловсролын 84 сургууль байгаагаас 50 нь 35-39 бүлэг дүүргэлттэй, 23 нь 40-44 хүүхдийн бүлэг дүүргэлттэй, 11 нь 45 ба түүнээс дээш хүүхдийн бүлэг дүүргэлттэйгээр хичээллэж байна.

3. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧИД


Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид, сургалтын хөтөлбөрөөр

Хичээлийн жил	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид				
	Нийт	Өдөр	Орой	Эчнээ	Дүйцсэн
2018-2019	600,384	593,150	108	219	6,917
2019-2020	646,839	640,449	88	123	6,179
2020-2021	686,321	680,837	51	93	5,340
2021-2022	717,451	712,353	33	102	4,963

Ерөнхий боловсролын сургуульд 2021-2022 оны хичээлийн жилд нийт 717,451 мянган (өдрөөр 712,353, оройгоор 33, эчнээгээр 102, дүйцсэн хөтөлбөрөөр 4,963) суралцагч өдөр, орой, эчнээ, дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж байна.

Суралцагчдын тоо өнгөрсөн хичээлийн жилээс 31,130-аар, үүнээс өдрөөр суралцагч 31,516-аар, эчнээгээр суралцагч 9-өөр тус тус өссөн бол оройгоор суралцагч 18-аар, дүйцсэн хөтөлбөрөөр суралцагч 377-оор тус тус буурсан байна.


Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид, боловсролын түвшин, өмчийн хэлбэрээр



848 сургуульд нийт 712,353 хүүхэд өдрөөр суралцаж байгаагийн 658,634 нь төрийн өмчийн сургуульд, 53,719 нь хувийн өмчийн сургуульд суралцаж байна.

Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад бага ангийн суралцагчид 14,576-аар, дунд ангийн суралцагчид 16,195-аар, ахлах ангийн суралцагчид 745-аар тус тус өссөн байна.

Сум болон багийн ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид




Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид, байршил, өмчийн хэлбэрээр

Байршил	Улсын хэмжээнд				Төрийн өмчийн			
	Нийт суралцагчид	Бага анги	Дунд анги	Ахлах анги	Нийт суралцагчид	Бага анги	Дунд анги	Ахлах анги
Баг	6,648	4,165	1,836	647	6,648	4,165	1,836	647
Сум	180,540	93,004	63,649	23,887	179,707	92,525	63,441	23,741
Аймаг	184,819	92,051	61,671	31,097	177,645	89,201	59,052	29,392
Нийслэл	340,346	182,260	111,192	46,894	294,634	158,671	97,243	38,720
Нийт	712,353	371,480	238,348	102,525	658,634	344,562	221,572	92,500

ЕБС-д суралцаж буй нийт 712.4 мянган суралцагчийн 6.6 мянга нь багийн төвийн сургуульд, 180.5 мянга нь сумын төвийн сургуульд, 184.8 мянга нь аймгийн төвийн сургуульд, 340.3 мянга нь нийслэлийн сургуульд суралцаж байна.

Төрийн өмчийн сургуульд суралцаж буй нийт 658.6 мянган суралцагчийн 6.6 мянга нь багийн төвийн сургуульд, 179.7 мянга нь сумын төвийн сургуульд, 177.6 мянга нь аймгийн төвийн сургуульд, 294.6 мянга нь нийслэлийн сургуульд суралцаж байна.

Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид, ээлжээр, дүнд эзлэх хувиар



Суралцагчдын 481.9 мянга нь нэгдүгээр ээлжид, 229.9 мянга нь хоёрдугаар ээлжид, 460 суралцагч гуравдугаар ээлжид хичээллэж байна.

МАЛЧИН ӨРХИЙН ХҮҮХЭД



Ерөнхий боловсролын сургуульд малчин өрхийн 128.2 мянган хүүхэд өдрөөр суралцаж байгаа нь өмнөх оны хичээлийн жилээс 3.8 мянга (3.0%)-аар нэмэгдсэн байна.



Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа малчин өрхийн хүүхэд, аймгаар

Аймаг, нийслэл	2018/2019	2019/2020	2020/2021	2021/2022
Бүгд	114,198	119,080	124,444	128,228
Баруун бүс	33,555	34,346	35,456	35,420
Баян-Өлгий	7,943	8,133	8 504	8,422
Говь-Алтай	5,493	5,571	5,682	5,611
Завхан	5,685	5,963	6,203	6,282
Увс	7,005	7,136	7,256	7,353
Ховд	7,429	7,543	7,811	7,752
Хангайн бүс	42,740	44,271	46,071	47,079
Архангай	9,688	10,107	10,299	10,416
Баянхонгор	7,655	7,851	8,215	8,353
Булган	4,115	4,341	4,560	4,694
Орхон	1,563	1,661	1,746	1,806
Өвөрхангай	9,114	9,098	9,417	9,683
Хөвсгөл	10,605	11,213	11,834	12,127
Төвийн бүс	19,440	20,453	21,187	22,140
Говьсүмбэр	573	634	719	752
Дархан-Уул	1,609	1,695	1,748	1,840
Дорноговь	2,653	2,738	2,883	3,061
Дундговь	3,721	3,861	3,899	4,006
Өмнөговь	3,033	3,196	3,226	3,382
Сэлэнгэ	2,691	2,841	3,018	3,091
Төв	5,160	5,488	5,694	6,008
Зүүн бүс	12,985	13,737	14,670	15,596
Дорнод	2,902	3,129	3,355	3,708
Сүхбаатар	5,060	5,395	5,768	6,044
Хэнтий	5,023	5,213	5,547	5,844
Улаанбаатар	5,478	6,273	7,060	7,993




ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД



Ерөнхий боловсролын сургуульд 5,606 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа нь өмнөх оны хичээлийн жилээс 22-оор буурсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нийт суралцагчдын 0.8 хувийг эзэлж байна.



ЕБС-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд



ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, бэрхшээлийн төрлөөр


Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Үүнээс:					
		Харааны	Сонголын	Хэл ярианы	Оюун ухааны	Бие эрхтний	Хавсарсан
2018-2019	6,518	1,638	712	958	931	956	1,323
2019-2020	6,053	1,358	633	857	885	894	1,426
2020-2021	5,628	1,129	568	732	833	850	1,516
2021-2022	5,606	950	521	647	906	902	1,680



ЕБС-д суралцаж байгаа нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 950 нь харааны бэрхшээлтэй, 1,680 нь хавсарсан хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байна.

НЭГДҮГЭЭР АНГИД ЭЛСЭГЧИД

Нэгдүгээр ангид шинээр элссэн суралцагчид, өмчийн хэлбэрээр



Нэгдүгээр ангид 75,845 хүүхэд суралцаж байгаагийн 75,518 (99.6%) нь шинээр элссэн суралцагч байна. Нийт шинээр элсэгчид өмнөх оны хичээлийн жилээс 2.7 мянгаар буурсан байна. Нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн 69,527 нь төрийн өмчийн сургуульд, 5,991 нь хувийн сургуульд элсжээ.

Нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн дотор сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь



Нийт шинээр элсэгчдийн 88.5% нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байгаа нь өмнөх оноос 2.5 пунктээр өссөн байна. Харин шинээр элсэгчдийн 11.5 хувь нь сургуульд элсэхийн өмнө сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй байна.


Нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн дотор сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь, аймгаар



Нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн дотор сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн эзлэх хувийг аймгаар авч үзвэл, хамгийн өндөр нь Сүхбаатар аймагт (97.8%), хамгийн бага нь Баян-Өлгий аймагт (64.6%) байна.


"Цэвэр жин" буюу Net Enrollment Ratio-(NER) нь тухайн шатанд хамрагдвал зохих насны хүүхдийн хэдэн хувь хамрагдсаныг илэрхийлнэ.

Нэгдүгээр ангид элсэгчдийн элсэлтийн цэвэр жин



Нэгдүгээр ангид элсэгчдийн элсэлтийн цэвэр жин 2021-2022 оны хичээлийн жилд 90.0 хувь байгаа нь өмнөх оны хичээлийн жилээс 2.5 пунктээр буурсан байна.

Нэгдүгээр ангид элсэгчдийн элсэлтийн цэвэр жин, аймгаар



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХАМРАН СУРГАЛТ

Хамран сургалтын цэвэр жин, ангиар



Тайлбар: 2021-2022 оны хичээлийн жилийн хамран сургалтын түвшнийг тооцохдоо 2020 оны жилийн эцсийн суурин хүн амын тоог нас дэвшүүлэх аргачлалаар тооцож урьдчилсан гүйцэтгэлээр тооцсон.



Бага боловсролын (1-5-р анги) хамран сургалтын цэвэр жин 2021-2022 оны хичээлийн жилд 95.7 хувь болж, өмнөх оны хичээлийн жилээс 0.4 пунктээр буурсан байна. Дунд ангийн (6-9-р анги) хамран сургалтын цэвэр жин 2021-2022 оны хичээлийн жилд 93.8 хувь болж, өмнөх оны хичээлийн жилээс 0.2 пунктээр өссөн байна.



Хамран сургалтын бохир жин, ангиар




Тайлбар: 2021-2022 оны хичээлийн жилийн хамран сургалтын түвшнийг тооцохдоо 2020 оны жилийн эцсийн суурин хүн амын тоог нас дэвшүүлэх аргачлалаар урьдчилсан гүйцэтгэлээр тооцсон.



Улсын хэмжээнд бага боловсролын (1-5 анги) хамран сургалтын бохир жин (нас харгалзахгүйгээр тооцсон) 2021-2022 оны хичээлийн жилд 97.0 хувь болж, өмнөх оны хичээлийн жилээс 0.3 пунктээр, дунд боловсролынх 96.3 хувь болж, өмнөх оны хичээлийн жилээс 0.3 пунктээр тус тус буурсан байна.

Бага болон дунд ангийн хамран сургалтын цэвэр жин, аймгаар



Дунд (6-9 анги)

Бага (1-5 анги)



Бага боловсролын хамран сургалтын цэвэр жинг аймгаар Дархан-Уул аймагт (99.7%) хамгийн өндөр байгаа нь улсын дунджаас 4.0 пунктээр өндөр, Булган аймагт (87.5%) хамгийн бага байгаа нь улсын дунджаас 8.2 пунктээр доогуур байна.



Бага болон дунд боловсролын хамран сургалтын цэвэр жин, дүүргээр, 2021-2022 оны хичээлийн жил




Бага (1-5 анги)

Дунд (6-9 анги)




Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин Багануур, Баянгол, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүдэд 100 хувиас өндөр байгаа нь ойролцоо дүүргийн хүүхдүүд суралцдагтай холбоотой байж болох юм.

Суурь болон бүрэн дунд боловсролын хамран сургалтын цэвэр жин, аймгаар



Суурь болон бүрэн дунд боловсролын хамран сургалтын цэвэр жин, дүүргээр





ЭЭЛЖИЙН КОЭФФИЦИЕНТ

 Ээлжийн коэффициент ба бүлэг дүүргэлтийн харьцуулалт, 2020-2021 оны хичээлийн жил

Ээлжийн коэффициент	Нийт сургуулийн тоо	Бүлэг дүүргэлт ба сургуулийн тоо			
		30 хүртэлх хүүхэдтэй	30-40 хүртэлх	40-50 хүртэлх	50+
0-0.5 хүртэлх	76	75	1		
0.6-1 хүртэлх	196	184	8	3	1
1-1.5 хүртэлх	473	337	117	17	2
1.5-2 хүртэлх	54	38	15	1	
2+	37	7	20	10	
Бүгд	836	641	161	31	3

Тайлбар: Ээлжийн коэффициентыг тооцох орчны захиргааны статистикийн мэдээлэл 2022.01 сард гарах тул энэхүү танилцуулгад 2020-2021 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийг үндэслэн тооцсон үр дүнг орууллаа.

 Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 307-91-237 тушаалын хавсралтад анги дүүргэлтийг бага ангид 30-35 хүүхэдтэй, дунд, ахлах ангид 32-35 байх нормативыг баталсан.


 Бага, дунд боловсролын хүртээмжтэй холбоотой тулгамдсан асуудлын нэг нь 2030 он гэхэд бага, дунд сургуулийн суралцагчийн тооны өсөлт юм. Хүн ам зүйн энэхүү өөрчлөлт нь бүлэг дүүргэлт, ээлжийн коэффициентыг улам нэмэгдүүлэхээр байна.*

Ахлах ангиуд бага болон дунд ангиудаас илүүтэйгээр 2 ээлжээр, 40-өөс дээш хүүхдийн бүлэг дүүргэлттэй хичээллэж байна.



4. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙР

Дотуур байртай сургуулийн тоо, дотуур байрны тоо




Улсын хэмжээнд 415 сургууль 548 дотуур байртай байна. Улаанбаатарт 15 сургууль, хөдөө орон нутагт 400 сургууль дотуур байртай байна.

Дотуур байрны хүчин чадал, түүнд амьдарч буй хүүхдийн тоо



Дотуур байрны нийт хүчин чадал 47,030 байгаагаас 32,576(69.3%) хүүхэд дотуур байранд амьдарч байна.

Дотуур байрны барилгын тоо, 2021-2022 оны хичээлийн жил




Нийт дотуур байрны барилгын тоо 548 байгаагийн 489 (89.2%) нь стандартын, 59(10.8%) нь стандартын бус байр байна.

■ Стандартын бус ■ Стандартын
● Дотуур байрны барилгын нийт тоо

Дотуур байранд амьдарч буй суралцагчид


Хичээлийн жил	Суралцагчид			Малчдын хүүхэд			Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
	Хүсэлт гаргасан	Амьдарч буй	Дотуур байрны хангалт	Хүсэлт гаргасан	Амьдарч буй	Дотуур байрны хангалт	
2018-2019	38,244	34,706	90.7	28,690	26,396	92.0	632
2019-2020	38,698	35,757	92.4	29,029	27,136	93.5	557
2020-2021	38,071	35,000	91.9	29,023	26,866	92.6	486
2021-2022	34,546	32,576	94.3	26,458	25,169	95.1	430

 2021-2022 оны хичээлийн жилийн байдлаар 34,546 хүүхэд дотуур байранд амьдрах хүсэлт гаргаснаас 32,576 (94.3%) хүүхэд дотуур байранд амьдарч байна. Хүсэлт гаргасан нийт хүүхдийн 26,458 (76.8%) нь малчдын хүүхэд байна.

Дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан малчдын хүүхдийн 25,169 (95.1%) нь дотуур байранд амьдарч байна.

Дотуур байранд амьдарч буй суралцагчид, ангиар


Хичээлийн жил	Бүгд	Бага анги	Дунд анги	Ахлах анги
2018-2019	34,706	12,802	13,996	7,908
2019-2020	35,757	12,646	14,182	8,929
2020-2021	35,000	11,975	14,261	8,764
2021-2022	32,576	11,098	13,700	7,778

 Дотуур байранд амьдарч байгаа суралцагчдын 11,098 (34.1%) нь бага ангийн, 13,700 (42.1%) нь дунд ангийн, 7,778 (23.8%) нь ахлах ангийн суралцагчид байна.

Дотуур байранд ажиллагчид




Дотуур байрны нийт ажиллагчид	3,436
Байрны багш	716
Тогооч	735
Бусад	1,985

 Нийт 548 дотуур байранд 3,436 ажиллагчид ажиллаж байгаагаас 716 (20.8%) дотуур байрны багш, 735 (21.4%) нь тогооч, 1,985 (57.8%) нь бусад ажиллагчид байна. Бусад гэдэгт үйлчлэгч, слесарь, манаач зэргийг оруулсан болно.

5. ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

Үдийн цай, хоолны үйлчилгээнд хамрагдаж буй 1-5 дугаар ангийн нийт суралцагчийн тоо




Эх үүсвэр: Ерөнхий боловсролын сургуулийн 2018-2021 оны захиргааны статистик мэдээ



2021-2022 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн I-V ангийн 371,480 суралцагч үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж байгаа бөгөөд өмнөх оны хичээлийн жилээс 14,576 суралцагчаар өссөн байна.


Ерөнхий боловсролын сургуулийн усан хангамж



Ерөнхий боловсролын сургуулийн усан хангамж, ундны цэвэр усны хүртээмж, хоолны газрын нөхцөл байдлыг тодруулах судалгаанд хамрагдсан төрийн өмчийн 619 сургуулийн 49.8 хувь нь төвлөрсөн усан хангамжтай, 36.5 хувь нь зөөврийн усан хангамжтай, 13.7 хувь нь хэсгийн шугам сүлжээнд холбогдсон байна.

Эх үүсвэр: БШУ-ны яамны Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсээ хийсэн "Ерөнхий боловсролын сургуулийн орчин, нөхцөл байдлын судалгаа"-ны үр дүн, 2021 он

Ерөнхий боловсролын сургуулийн хоолны үйлчилгээ



Судалгаанд хамрагдсан нийт 748 сургуулийн 545 (72.9%) нь 5 өдөр халуун хоолоор, 158 (21.1%) нь холимог хэлбэрээр, 45 (6.0%) нь 5 өдөр бэлэн бүтээгдэхүүнээр үдийн хоолны үйлчилгээг зохион байгуулж байна

Эх үүсвэр: 2021-2022 оны хичээлийн жилд 1-5 дугаар ангийн сурагчдын үдийн цай/хоолны үйлчилгээний зохион байгуулалтын мэдээлэл, 2021 оны 10-р сарын байдлаар, БШУЯ-ны Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс


Хоол үйлдвэрлэлийн байрны нөхцөл байдал



Судалгаанд хамрагдсан төрийн өмчийн 672 сургуулийн 18 (2.7%) нь огт гал тогоогүй бол 396 (58.9%) нь зориулалтын гал тогоотой, 258 (38.4%) нь зориулалтын бус, хүчин чадал хүрэлцээгүй гал тогоотой үйл ажиллагаа эрхэлж байна.

Эх үүсвэр: БШУ-ны яамны Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсээс хийсэн “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний нөхцөл байдлын судалгаа”-ны үр дүн, 2020 он

Хоол үйлдвэрлэлийн ажиллагааны хэлбэр



Судалгаанд хамрагдсан төрийн өмчийн 672 сургуулийн 514 (76.5%) нь гал тогоог түрээсийн хэлбэрээр ажиллуулдаг бол 158 (23.5%) нь гал тогоогоо өөрсдөө ажиллуулдаг байна.

Эх үүсвэр: БШУ-ны яамны Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсээс хийсэн “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний нөхцөл байдлын судалгаа”-ны үр дүн, 2020 он

Хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хангалт




Судалгаанд хамрагдсан төрийн өмчийн 672 сургуулийн 184 (27.4%) нь гал тогооны иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдсан бол 309 (46.0%) нь иж бүрэн тоног төхөөрөмж шаардлагатай байна. Харин нэмэлт тоног төхөөрөмж шаардлагатай сургууль 179 (26.6%) байна.

Тайлбар: ТТ - тоног төхөөрөмж

Эх үүсвэр: БШУ-ны яамны Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсээс хийсэн “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний нөхцөл байдлын судалгаа”-ны үр дүн, 2020 он

Хоол үйлдвэрлэлийн хүний нөөц



Тайлбар: СӨБ – Сургуулийн өмнөх байгууллага, ЕБС – Ерөнхий боловсролын сургууль
 Эх үүсвэр: БШУ-ны яамны Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсээс хийсэн “Төрийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулийн тогоочийн судалгаа”-ны үр дүн, 2020 оны 6-р сарын байдлаар



Судалгаанд хамрагдсан төрийн өмчийн сургууль, цэцэрлэгт нийт 2,287 тогооч ажиллаж байгаагийн 1,003 нь сургуулийн тогооч, 1,284 нь цэцэрлэгийн тогооч байна. Судалгаанд хамрагдсан нийт тогоочийн 180 (7.9%) нь мэргэжлийн зэрэггүй бол 2,107 (92.1%) нь мэргэжлийн зэрэгтэй байна.



5. ХҮҮХДИЙН СУРАХ СУУРЬ ЧАДВАР



Энгийн эхийг уншиж ойлгох чадвар бол хүүхдийн сурвал зохих суурь чадваруудын нэг юм. Хүүхэд бага ангидаа тоог унших, бичих, нэмэх, хасах, үржүүлэх, хуваах аргад сайтар суралцах нь цаашдаа математикт амжилт гаргахад нь ихээхэн чухал байдаг байна. 2018 оны “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-ны үр дүнгээс харахад, 7-14 насны нийт хүүхдүүдийн 61.6 хувь нь унших суурь чадвар эзэмшсэн, 51.5 хувь нь тоо бодох суурь чадвар эзэмшсэн байна. Унших суурь чадвар баруун бүсэд 37.4 хувь, тоо бодох суурь чадвар Улаанбаатар хотод 43.9 хувь гарсан нь хамгийн бага байна. Баруун бүсэд унших суурь чадвар бага гарсан нь уг үзүүлэлт Баян-Өлгий аймагт 10.0 хувь гарснаас шалтгаалсан байна.

Суурь чадвар эзэмшсэн хүүхдийн эзлэх хувь, 2018 он


Үзүүлэлт	Унших суурь чадвар эзэмшсэн хүүхдийн эзлэх хувь			Тоо бодох суурь чадвар эзэмшсэн хүүхдийн эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Улсын дүн	61.6	61.2	62.1	51.5	49.9	53.2
Бүс						
Баруун	37.4	37.0	37.8	47.7	44.8	50.2
Хангай	73.6	70.4	76.3	53.8	51.9	55.5
Төв	70.4	69.7	71.3	64.6	64.1	65.2
Зүүн	57.1	55.6	58.8	61.0	59.7	62.3
Улаанбаатар	60.8	61.3	60.1	43.9	41.5	46.3
Зорилгод аймаг, дүүрэг						
Баян-Өлгий аймаг	10.0	9.8	10.3	50.1	47.8	52.5
Баянхонгор аймаг	54.9	55.0	54.7	43.9	41.5	46.3
Говь-Алтай аймаг	55.9	51.9	60.1	60.8	59.1	62.3
Завхан аймаг	49.1	44.5	54.4	54.2	53.7	54.7
Өмнөговь аймаг	70.7	70.6	70.8	55.0	56.8	53.0
Хөвсгөл аймаг	70.0	66.9	73.6	53.6	51.5	55.8
Баянзүрх дүүрэг	64.3	67.7	61.3	-	-	-
Налайх дүүрэг	70.2	66.7	73.4	25.1	(19.1)	(33.6)
Байршил						
Нийслэл	60.8	61.3	60.1	43.9	41.5	46.3
Аймгийн төв	65.8	64.2	67.4	60.8	59.1	62.3
Сумын төв	63.7	61.3	66.4	55.0	56.8	53.0
Хөдөөгийн баг	57.7	57.9	57.5	53.6	51.5	55.8

Эх үүсвэр: ҮСХ-ны “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-ны нэгдсэн тайлан, 2018 он

СУРАХ СУУРЬ ЧАДВАР, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 4.1.1



Унших болон тоо бодох суурь чадвартай 2-3 ангийн хүүхдийн хувь, хүйсээр, 2018 он



Унших чадвар: 1. Өгөгдсөн эх доторх үгийн 90, түүнээс дээш хувийг зөв уншсан, 2. шууд хариулах 3 асуултад зөв хариулсан, 3. Учир шалтгаан тодруулсан 2 асуултад зөв хариулсан 2,3-р ангид сурдаг хүүхдийн хувь

Тоо бодох чадвар: 1. Тоо таних, 2. тоо жиших, 3 нэмэх үйлдэл, 4. зүй тогтолыг олох дасгалуудыг зөв хийсэн 2,3-р ангид сурдаг хүүхдийн хувь



Унших суурь чадварын үзүүлэлтийг харахад хүүхдүүд эхийг уншиж байгаа ч ойлгож, асуултад хариулах чадвар нь харьцангуй бага байна. Тоо бодох чадварын хувьд нэмэх үйлдэл болон зүй тогтолыг зөв тодорхойлох дасгалуудыг харьцангуй тааруу хийсэн байна.

Унших болон тоо бодох суурь чадварын хувьд 4 дүгээр анги хүртэл өсч байгаа хэдий ч түүнээс төдийлөн сайн өсөхгүй байгаа нь анхаарал татаж байна.


Унших болон тоо бодох суурь чадвартай хүүхдийн хувь, ангиар 2018 он



Эх үүсвэр: УСХ-ны “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-ны нэгдсэн тайлан, 2018 он

ГЭРТЭЭ СУРАЛЦАХ, ХИЧЭЭЛ ДАВТАХ ОРЧИН НӨХЦӨЛ


Гэртээ 3, түүнээс олон унших номтой, ном уншдаг эсвэл уншиж өгдөг 7-14 насны хүүхдийн хувь, 2018 он



Эх үүсвэр: УСХ-ны “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-ны нэгдсэн тайлан, 2018 он


СУРАЛЦАГЧДЫН МЭДЛЭГ, ЧАДВАРЫН АХИЦ, АМЖИЛТЫН ТҮВШИН

9-р ангид суралцагчдын Математикийн хичээлийн улсын шалгалтын үнэлгээ



Эх үүсвэр: БШУЯ-ны Захиргааны статистикийн мэдээ

9-р ангид суралцагчдын Монгол хэлний хичээлийн улсын шалгалтын үнэлгээ



Эх үүсвэр: БШУЯ-ны Захиргааны статистикийн мэдээ

6. БОЛОВСРОЛЫН ТЭНЦВЭРТ БАЙДАЛ (ПАРИТЕТ)-ЫН ИНДЕКС



Боловсролын түвшнээр тооцсон "Тэнцвэрт байдал (паритет)-ын индекс"-ийг Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны 2018 оны үр дүнгээр хүйсээр, өрхийн аж байдлын түвшнээр, байршлаар тооцоолон харьцуулан харуулав.




Охидын хамран сургалтын цэвэр жин (засварласан) болон хөвгүүдийн хамран сургалтын цэвэр жингийн (засварласан) харьцаа



Эх үүсвэр: ҮСХ-ны "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа"-ны нэгдсэн тайлан, 2018 он




Доогуур аж байдалтай (хамгийн доод 20%) өрхөд амьдарч байгаа хүүхдийн хамран сургалтын цэвэр жинг (засварласан) болон Дээгүүр аж байдалтай (хамгийн дээд 20%) өрхөд амьдарч байгаа хүүхдийн хамран сургалтын цэвэр жингийн (засварласан) харьцаа



Эх үүсвэр: ҮСХ-ны "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа"-ны нэгдсэн тайлан, 2018 он



Хөдөө амьдарч байгаа хүүхдийн хамран сургалтын цэвэр жин болон (засварласан) хотод амьдарч байгаа хүүхдийн хамран сургалтын цэвэр жингийн (засварласан) харьцаа



Эх үүсвэр: ҮСХ-ны "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа"-ны нэгдсэн тайлан, 2018 он



Бага болон дунд ангид суралцагчдын хувьд хүйс, өрхийн аж байдал, байршлаар тооцсон боловсролын тэгш байдлын индекс харьцангуй жигд 0.97-1.03 байна. Харин ахлах ангийн хувьд хамран сургалтын цэвэр жингээр тооцсон тэгш байдлын индексийг харахад хөдөөгийн, доогуур аж байдалтай өрхийн, хөвгүүд суурь боловсрол эзэмшээд цааш үргэлжлүүлэн ахлах ангид суралцах нь бага байгааг харж болохоор байна.




7. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙГ ТӨГСӨГЧИД



Монгол Улсын Их хурлын 2006 оны 89-р тогтоолын дагуу ЕБС-ийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлсэн ба 2006 онд анх нэгдүгээр ангид элссэн хүүхдүүд 2018-2019 оны хичээлийн жилд бүтэн 12 жил суралцан төгссөн байна.

ЕБС-ийг өдрөөр суралцан төгсөгчид, ангиар




ЕБС-ийн 9-р ангийг 44.9 мянга, 12-р ангийг 34.8 мянга хүүхэд өдрөөр суралцаж төгссөн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 12-р ангийг өдрөөр суралцан төгсөгчид, аймгаар, 2020/2021



Төгсөлтийн хувь, боловсролын түвшнээр, 2020-2021




ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ



Элсэлтийн ерөнхий шалгалт нь Монгол Улсын хэмжээнд их, дээд сургууль, коллежид элсэгчдийн сурах ерөнхий чадвар, мэдлэгийн түвшнийг тогтоох, шалгуулагчдыг эрэмбэлэн жагсаахад чиглэгдсэн нормд тулгуурласан үнэлгээний хэлбэр юм.

ЭЕШ өгсөн нийт хүүхдийн тоо, байршлаар, 2021 он



2021 онд 37,054 хүүхэд элсэлтийн ерөнхий шалгалт өгсний 17,560 (47.4%) нь нийслэл хотод, 19,494 (52.6%) нь хөдөө, орон нутагт шалгалт өгсөн байна. Нийт шалгалт өгсөн хүүхдүүдийн 0.6 хувь нь 800 оноо авсан байна.

Эх үүсвэр: Боловсролын үнэлгээний төвийн статистик тайлангийн систем, 2021 он

Элсэлтийн ерөнхий шалгалтад орсон нийт хүүхдийн тоо (давхардсан тоогоор) ба 800 оноо авсан хүүхдийн тоо, 2018-2021

Хичээл	2018		2019		2020		2021	
	Нийт шалгуулагчид	800 оноо	Нийт шалгуулагчид	800 оноо	Нийт шалгуулагчид	800 оноо	Нийт шалгуулагчид	800 оноо
Математик	31,045	42	12,232	18	21,152	27	21,441	25
Монгол хэл	1,610	2	546	1	11,897	22	9,991	27
Нийгмийн тухай мэдлэг	17,205	18	6,709	13	18,651	26	18,616	31
Англи хэл	27,567	46	10,690	15	19,114	27	19,277	23
Орос хэл	26,733	46	10,978	7	764	67	680	72
Газар зүй	1,021	55	646	39	783	1	647	1
Физик	1,707	2	486	1	8,090	11	8,291	14
Биологи	14,194	22	5,140	7	5,292	6	5,764	5
Хими	7,453	11	3,072	6	5,243	7	5,790	10
Монгол улсын түүх	7,426	11	3,116	4	972	2	689	1
Нийт	135,961	255	53,615	111	91,958	196	91,186	209

8. АЖИЛЛАГЧИД БОЛОН ҮНДСЭН БАГШ



Ерөнхий боловсролын сургуульд 56.2 мянган ажиллагчид ажиллаж байгаагийн 50.0 (89.0%) мянга нь төрийн өмчийн сургуульд, 6.2 (11.0%) мянга нь хувийн сургуульд ажиллаж байна. Ажиллагчдын тоо өмнөх хичээлийн жилээс 1,730 (төрийн өмчийн сургууль 1,310, хувийн сургууль 420)-аар нэмэгдсэн байна.

Ерөнхий боловсролын сургуульд 35.1 мянган үндсэн багш ажиллаж байгаагийн 31.2 (88.7%) мянга нь төрийн өмчийн сургуульд, 3.9 (11.3%) мянга нь хувийн өмчийн сургуульд ажиллаж байна.



Ерөнхий боловсролын сургуулийн ажиллагчид



■ Төрийн өмчийн ■ Хувийн өмчийн ● Ажиллагчдын тоо




Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш




■ Төрийн өмчийн ■ Хувийн өмчийн ● Багшын тоо

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн ажиллагчид, байршлаар



Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш, ангиар



Нийт багшийн 33.7 хувь буюу 11.8 мянга нь бага анги, 66.3 хувь буюу 23.3 мянга нь дунд, ахлах ангийн багш нар байна.




Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш, байршил, өмчийн хэлбэрээр

Байршил	Улсын хэмжээнд				Төрийн өмчийн			
	Нийт багш	Бага анги	Дунд анги	Ахлах анги	Нийт багш	Бага анги	Дунд анги	Ахлах анги
Баг	514	284	169	61	514	284	169	61
Сум	10,300	3,559	4,493	2,248	10,251	3,535	4,485	2,231
Аймаг	8,890	2,736	3,819	2,335	8,342	2,595	3,559	2,188
Нийслэл	15,406	5,241	6,918	3,247	12,049	4,067	5,517	2,465
Нийт	35,110	11,820	15,399	7,891	31,156	10,481	13,730	6,945

Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа мэргэжлийн багшийн хангалт




Тайлбар: Мэргэжлийн багшийн эзлэх хувь - Дипломоос дээш боловсролтой багшийн хувь


 Мэргэжлийн багшийн хангалт 2021-2022 оны хичээлийн жилд 99.5 хувь байгаа нь өмнөх хичээлийн жилээс 0.3 пунктээр буурсан байна.

Мэргэжлийн багшийн хангалт, аймгаар



Улсын дундаж-99.5

 Нийт багшийн 50.3 хувь нь 10 ба түүнээс дээш жил ажилласан багш нар байна.

 Мэргэжлийн багшийн хангалтыг аймгаар харуулбал, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Дархан-Уул, Орхон аймагт (100.0%) хамгийн өндөр байгаа бол Хэнтий аймагт (97.9%) хамгийн бага байна.

Харин дүүргээр авч үзвэл, Сонгинохайрхан, Багахангай, Багануур дүүрэгт (100.0%) хамгийн өндөр, Налайх дүүрэгт (97.3%) хамгийн бага байна.

Мэргэжлийн багшийн хангалт, дүүргээр



Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн нас, хүйс, дүнд эзлэх хувь



Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн 28.6 (81.6%) мянга нь эмэгтэй, 6.5 (18.4%) мянга нь эрэгтэй багш байгаа нь хүйсийн харьцаа алдагдсаныг харуулж байна. Нийт багшийн 29.4 хувийг 30-39 насны эмэгтэй багш эзэлж байна.


Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа багш нарын насны ангилал

Хичээлийн жил	30 хүртэл	30-39	40-49	50-59	60+
2018-2019	8,606	10,741	7,317	3,462	285
2019-2020	8,912	11,361	7,820	3,607	385
2020-2021	9,147	12,339	8,482	3,650	455
2021-2022	9,058	12,913	8,794	3,823	522

Багш нарын ажилласан жил буюу ажлын туршлагыг авч үзэхэд нийт багш нарын 6.0 хувь нь анхны жилдээ, 26.4 хувь нь 1-5 жил, 20.7 хувь нь 6-10 жил, 16.5 хувь нь 11-15 жил, 12.5 хувь нь 16-20, 6.4 хувь нь 21-25, 11.5 хувь нь 25-аас дээш жил ажиллаж байна.

Багш нарын 46.2 хувь нь мэргэжлийн зэрэгтэй тэдгээрийн 1.5 хувийг зөвлөх, 37.0 хувийг тэргүүлэх, 61.5 хувийг заах аргач зэрэгтэй багш бүрдүүлж байна.

Ерөнхий боловсролын сургууль ажиллаж байгаа багш нарын ажлын туршлага, ажилласан жилээр




Нэг багшид ногдох хүүхдийн тоо



2021-2022 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ЕБС-ийн нэг багшид дунджаар 20 хүүхэд ногдож байгаа бол бага ангийн нэг багшид 31.1 хүүхэд ногдож байна.

Нэг багшид ногдох хүүхдийн тоо, аймгаар



Ерөнхий боловсролын сургуулийн нэг багшид ногдох хүүхдийн тоог аймгаар харуулбал, хамгийн өндөр нь Дорноговь аймаг (22.1) байгаа бол хамгийн бага нь Баян-Өлгий, Говь-Алтай аймаг (14.9) байна.

Нэг багшид ногдох хүүхдийн тоо, дүүргээр




Дүүргээр авч үзвэл, энэхүү үзүүлэлт Сонгинохайрхан дүүрэгт хамгийн өндөр, харин Багахангай дүүрэгт хамгийн бага байна.

9. ЦАХИМ СУРГАЛТ

 Medle.mn-ий сургалтын цахим контентын сан



2021 оны 12-р сарын 22-ны байдлаар


 Medle.mn-д 2021 онд 147 сурах бичгийг HTML хэлэнд хөрвүүлэн агуулгыг текст хэлбэрээр хайх боломжтой болгож байршуулсан. ЕБС-ийн багш, суралцагчдад зориулсан MS OFFICE 365 программын ашиглалтын заавар хичээл бүхий 150 видео, өсвөр насны суралцагчдад зориулсан “Эрүүл мэндийн” агуулгаар 30 видео хичээлийг тус тус нэмэлтээр байршуулсан.




2021-2022 оны хичээлийн жилд ээлжит хичээлийн цахим контентын санд




2021 оны 12-р сарын 22-ны байдлаар

 2021 онд econtent.edu.mn цахим контентын системийг сургалт удирдлагын цахим платформ болгон хөгжүүлж, ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн “Ээлжит хичээлийн цахим контентын сан” бүрдүүлэх үйл ажиллагааны хүрээнд багш нарын дунд ээлжит хичээлийн цахим контент боловсруулах ажлыг 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн medle.mn сургалтын цахим платформд нээлттэй зохион байгуулж байна

Ерөнхий боловсролын сургуулийн нэг компьютерт ноогдох хүүхдийн тоо



Салбарын нийт интернэт сүлжээнд холбогдсон дотуур байр болон хичээлийн байрны тоо



Эх үүсвэр: БШУЯ-ны албан хэрэгцээнд зориулсан судалгааны үр дүн

10. ЗАРИМ ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТИЙН ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛАЛТ

Бага ангийн сурагч - багшийн харьцаа, улсаар 2018 он



Эх үүсвэр: Дэлхийн Банкны дата мэдээлэл


Ерөнхий боловсролын сургуульд элсэх албан ёсны насыг зарим улс орнуудаар харьцуулан харахад, Швед, Казахстанд 7 наснаас, Бразил 4 наснаас, Израйл 3 наснаас эхлэн элсүүлдэг байна. Харин манай улсын хувьд ерөнхий боловсролын сургуульд 6 наснаас эхлэн элсүүлдэг.

Бага ангийн сурагч - багшийн харьцаа, улсаар, 2019 он



Эх үүсвэр: ЮНЕСКО-гийн Статистикийн институт

Бага ангийн бүлэг дүүргэлт, улсаар, 2019




Бага ангийн бүлэг дүүргэлтийг зарим улсуудаар харьцуулан авч үзвэл, Европын холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын 22 гишүүн улсуудад 19.5 байгаа бол Монгол Улсад 31.7 байна.



11. ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ




Ерөнхий боловсролын нийт урсгал төсөв, тэрбум төгрөг



Боловсрол, шинжлэх ухааны салбарын 1.3 их наяд урсгал төсвийн 760.6 тэрбум төгрөг буюу 55.3% нь ерөнхий боловсролын салбарт зарцуулагдаж байна.



Боловсрол, шинжлэх ухааны салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017-2021 онуудад аймаг, нийслэлд хэрэгжүүлсэн сургуулийн төсөл, арга хэмжээ, тоогоор



The background features a light blue-to-white gradient. A grid of small white dots is overlaid on this gradient. In the lower half, a network of thin white lines connects various points, creating a complex, web-like pattern. The overall aesthetic is clean, modern, and technical.

ДЭЭД БОЛОВСРОЛЫН

ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ, 2021-2022

Үзүүлэлт	Бүгд	Хот	Хөдөө	Төрийн өмчийн	Хувийн өмчийн
Сургалтын байгууллагын тоо	88	80	8	20	68
Коллеж	3	3	-	-	3
Дээд сургууль	47	41	6	6	41
Их сургууль	38	36	2	14	24
Магадлан итгэмжлэгдсэн сургуулийн тоо	70	62	8	18	52
Коллеж	2	2	-	-	2
Дээд сургууль	32	26	6	5	27
Их сургууль	36	34	2	13	23
Суралцагчид	148,954	139,389	9,565	79,094	69,860
Эмэгтэй	91,034	84,420	6,614	46,739	44,295
Эрэгтэй	57,920	54,969	2,951	32,355	25,565
Диплом	3,155	1,862	1,293	2,621	534
Эмэгтэй	2,519	1,384	1,135	2,186	333
Эрэгтэй	636	478	158	435	201
Бакалавр	117,037	110,289	6,748	59,625	57,412
Эмэгтэй	69,803	65,445	4,358	34,077	35,726
Эрэгтэй	47,234	44,844	2,390	25,548	21,686
Магистр	25,300	23,802	1,498	14,168	11,132
Эмэгтэй	16,717	15,618	1,099	8,961	7,756
Эрэгтэй	8,583	8,184	399	5,207	3,376
Доктор	3,462	3,436	26	2,680	782
Эмэгтэй	1,995	1,973	22	1,515	480
Эрэгтэй	1,467	1,463	4	1,165	302
Шинээр элсэгч	30,545	28,055	2,490	17,852	12,693
Эмэгтэй	18,784	17,068	1,716	10,543	8,241
Эрэгтэй	11,761	10,987	774	7,309	4,452
Тухайн жилд 12 дугаар анги төгсөгчдөөс шинээр элсэгч	25,237	23,332	1,905	14,925	10,312
Эмэгтэй	15,370	14,128	1,242	8,884	6,486
Эрэгтэй	9,867	9,204	663	6,041	3,826
Дотуур байртай сургуулийн тоо	45	39	6	15	30
Дотуур байрны барилгын тоо	71	63	8	39	32
Дотуур байранд амьдарч буй хүүхэд	7,027	6,733	294	5,038	1,989
Эмэгтэй	4,518	4,340	178	3,092	1,426
Эрэгтэй	2,509	2,393	116	1,946	563
Нийт багш, ажиллагчид	12,175	10,962	1,213	7,620	4,555
Эмэгтэй	7,688	6,855	833	4,859	2,829
Эрэгтэй	4,487	4,107	380	2,761	1,726
Үндсэн багшийн тоо	6,102	5,544	558	3,769	2,333
Эмэгтэй	3,740	3,341	399	2,255	1,485
Эрэгтэй	2,362	2,203	159	1,514	848

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

1. ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА



Монгол Улсын хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилд 88 дээд боловсролын сургалтын байгууллагад 148,954 оюутан суралцаж, 12,175 багш, ажиллагчид ажиллаж байна.



Дээд боловсролын сургалтын байгууллага нь Боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу их сургууль, дээд сургууль, коллеж гэсэн ангилалтай байна. /Дээд боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйл/

Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, ангиллаар

Хичээлийн жилд	Дээд боловсролын сургалтын байгууллага				
	Бүгд	Их сургууль	Дээд сургууль	Коллеж	Гадаадын салбар сургууль
2018-2019	94	35	49	7	3
2019-2020	95	35	50	7	3
2020-2021	88	37	45	3	3
2021-2022	88	38	44	3	3



Дээд боловсролын сургалтын байгууллага 88 байгаагийн 38 (43.2%) нь их сургууль, 44 (50.0%) нь дээд сургууль, 3 (3.4%) нь коллеж, 3 (3.4%) нь гадаадын их сургуулийн салбар байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр



Их, дээд сургууль, коллежийн 65 (73.9 %) нь төрийн бус өмчийн, 20 (22.7 %) нь төрийн өмчийн, 3(3.4%) нь олон нийтийн/шашны өмчийн* сургууль байна.


Дээд боловсролын сургалтын байгууллагын 80 нь Улаанбаатар хотод, 8 нь хөдөө орон нутагт байрлаж байна.

*Дээд боловсролын салбарын статистикийн мэдээллийн маягт 2020 онд шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор байгууллагын өмчийн хэлбэрийн ангилалд өөрчлөлт орж, олон нийтийн/шашны гэсэн шинэ ангилал нэмэгдсэн болно.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй дээд боловсролын сургалтын байгууллагууд

Төрийн өмчийн	Төрийн бус өмчийн
1. Ховд их сургууль (Ховд)	1. Дархан дээд сургууль (Дархан-уул)
2. Дорнод их сургууль (Дорнод)	2. Маргад дээд сургууль (Орхон)
3. ХААИС-ийн харьяа Ургамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн (Дархан-Уул)	3. “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль (Орхон)
	4. Далай ван дээд сургууль (Хөвсгөл)
	5. Хүмүүнлэгийн дээд сургууль (Дархан-Уул)

Хөдөө орон нутагт салбартай дээд боловсролын сургалтын байгууллагууд



Байгууллагын магадлан итгэмжлэлийг сургуулийн ангиллаар авч үзвэл



Дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа явуулж буй 70 (79.5%) их, дээд сургууль, коллеж магадлан итгэмжлэгдсэн байгаа ба 2021 онд 8 сургууль шинээр магадлан итгэмжлэлд хамрагдсан байна. Байгууллагын магадлан итгэмжлэлийг сургуулийн ангиллаар авч үзвэл, 36 их сургууль, 32 дээд сургууль, 2 коллеж хамрагдсан байна.

Олон улсын магадлан итгэмжлэлд 17 сургуулийн 89 хөтөлбөр, дотоодын магадлан итгэмжлэлд 27 сургуулийн 195 хөтөлбөр, урьдчилсан магадлан итгэмжлэлд 43 сургуулийн 154 хөтөлбөр хамрагдсан байгаа ба 2021 онд шинээр 25 сургуулийн 92 хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байна.

2. ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАГЧИД



Нийт суралцагчид, боловсролын зэрэг, хүйсээр

Үзүүлэлт	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022
Бүх суралцагчид	157,625	148,446	147,293	148,954
Эмэгтэй	93,552	90,573	89,463	91,034
Эрэгтэй	64,073	57,873	57,830	57,920
Диплом	362	98	124	3,155
Эмэгтэй	191	14	17	2,519
Эрэгтэй	171	84	107	636
Бакалавр	130,545	119,203	119,108	117,037
Эмэгтэй	76,394	71,622	71,375	69,803
Эрэгтэй	54,151	47,581	47,733	47,234
Магистрантур	22,499	25,753	24,813	25,300
Эмэгтэй	14,554	17,066	16,291	16,717
Эрэгтэй	7,945	8,687	8,522	8,583
Докторантур	4,219	3,392	3,248	3,462
Эмэгтэй	2,413	1,871	1,780	1,995
Эрэгтэй	1,806	1,521	1,468	1,467



“Дээд боловсролын тухай хууль”-ийн 3.3-д “Дээд боловсролын зэрэг нь багц цагаар хэмжигдэх дипломын, бакалаврын, магистрын, докторын шатлалтай байна” гэж заасан



Дээд боловсролын сургалтын байгууллагад Нийт 149.0 мянган оюутан суралцаж байгаа нь өмнөх оны хичээлийн жилээс 1,661 (1.1%)-ээр өссөн байна.

Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг боловсролын зэргээр авч үзвэл, нийт суралцагчдын 3.2 мянга нь диплом, 117.0 мянга нь бакалавр, 25.3 мянга) нь магистр, 3.5 мянга нь докторын зэрэг эзэмшихээр суралцаж байна. Суралцагчдыг өмнөх онтой харьцуулахад, дипломын зэрэгт суралцагчид 3,031 (25.4 дахин их)-ээр, магистрантурт суралцагчдын тоо 487-оор, докторантурт суралцагчдын тоо 214-өөр тус тус өссөн бол, бакалаврын зэрэгт суралцагчид 2,071-ээр буурсан байна.



БСШУС-ын сайдын 2020 оны А/308 тоот тушаалаар “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх дипломын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/ индекс”-т нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүний дагуу эрүүл мэнд, нийгмийн хамгааллын мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулдаг дээд боловсролын байгууллагын дипломын боловсрол эзэмшигч оюутнуудын тоо нэмэгдсэн.



Нийт суралцагчид, хүйсээр



Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг хүйсээр авч үзвэл, нийт суралцагчдын 91.0 (61.1 %) мянга нь эмэгтэй, 57.9 (38.9%) мянга нь эрэгтэй байна.

Жендерийн тэнцвэрт байдлын индекс буюу 100 эрэгтэй суралцагч тутамд ногдох эмэгтэй суралцагчийн тоо 157 болж өнгөрсөн жилээс 3-аар нэмэгдсэн байна.




Хүйсийн тэнцвэрт байдлын индекс

Хичээлийн жилд	Хүйсийн тэнцвэрт байдлын индекс	Нийт суралцагчдад эмэгтэй оюутны эзлэх хувь
2018-2019	1.46	59.4
2019-2020	1.56	61.0
2020-2021	1.54	60.7
2021-2022	1.57	61.1




Суралцагчдын тоо, сургуулийн ангиллаар



Нийт суралцагчдын 132.8 мянга нь их сургуульд, 16.0 мянга нь дээд сургуульд, 224 нь коллежид суралцаж байгаа бол 234 нь гадаадын их сургуулийн салбар сургуульд суралцаж байна.

Суралцагчдын тоо, сургуулийн өмчийн хэлбэрээр



Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2021-2022 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 79.1 мянга нь төрийн өмчийн, 62.5 мянга нь хувийн өмчийн, 7.4 мянга нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд суралцаж байна.

Тайлбар: Төрийн бус өмчийн сургуулийн тоонд гадаадын салбар сургуулийн тоог оруулсан болно. Дээд боловсролын салбарын статистикийн мэдээллийн маягт 2020 онд шинэчлэгдэн баглагдсантай холбоотойгоор байгууллагын өмчийн хэлбэрийн ангилалд өөрчлөлт орж, олон нийтийн/шашны гэсэн шинэ ангилал нэмэгдсэн болно.

Нийт суралцагчид, сургуулийн байршлаар



Их, дээд сургууль, коллежид суралцагчдын 139.4 мянга нь Улаанбаатар хотод, 9.6 мянга нь хөдөө, орон нутагт суралцаж байна. Аймгаар авч үзвэл, 2021-2022 оны хичээлийн жилд хамгийн олон суралцагчтай нь Дархан-Уул аймаг 3.6 мянга, хамгийн цөөн суралцагчтай нь Хөвсгөл аймаг 44 оюутантай байна.

Монгол Улсын 18-24 насны нийт хүн ам 306,281 байгаагийн 117,037 (38.2%) нь бакалаврын боловсролд суралцагчид байна.

Тайлбар:

- 2021 оны хүн амын тоог ҮСХ-оос гаргасан 2020 оны суурин хүн амын тоог нас дэвшүүлэх зарчмаар тооцсон.
- Олон улсад бакалаврын зэргийн боловсрол олгох насны бүлгийг 18-24 нас гэж үздэг.


Эх үүсвэр: Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тодорхойлолтоос, <https://www.oecd-ilibrary.org/>

Нийт суралцагчид, хүйс, мэргэжлийн ерөнхий чиглэлээр, дүнд эзлэх хувь



Нийт суралцагчдыг мэргэжлийн ерөнхий чиглэлээр авч үзвэл, 2021-2022 оны хичээлийн жилд хамгийн олон нь буюу 43.0 мянга (28.8 %) нь бизнес, удирдахуй, хууль, эрх зүйн мэргэжлийн чиглэлд, хамгийн бага нь буюу 2.0 мянга (1.3 %) нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлгийн салбарын мэргэжлийг сонгон суралцаж байна.


Багш мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа явуулж буй сургуулийн тоо, өмчийн хэлбэрээр



2021-2022 оны хичээлийн жилд нийт 38 сургууль (төрийн өмчийн-8, хувийн өмчийн-30 сургууль) багш мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа ба нийт 12,620 оюутан суралцаж байгаа нь нийт суралцагчдын 8.5 хувийг эзэлж байна.



Монгол Улсад суралцаж буй гадаад оюутан, улсаар, дүнд эзлэх хувь




Монгол Улсын их, дээд сургууль, коллежид нийт 1,547 гадаад оюутан суралцаж байгаагаас хамгийн их буюу 76.4 хувь нь хөрш зэргэлдээ БНХАУ-ын оюутнууд байна.

ШИНЭЭР ЭЛСЭГЧИД




Шинээр элсэгчид, хүйсээр




Шинээр элсэгчид 2021-2022 оны хичээлийн жилд 30.5 мянга болж, өмнөх оны хичээлийн жилээс 5.4 мянгаар өссөн ба шинээр элсэгчдийн 61.5 хувь нь эмэгтэйчүүд байна.

Их, дээд сургууль, коллежид шинээр элсэгчид ба тухайн жилд 12 дугаар анги төгсөгчид



Шинээр элсэгчдийн дотор тухайн жилд 12 дугаар анги төгссөн хүүхдийн эзлэх хувь 2021-2022 оны хичээлийн жилд 82.6 хувь болж, өмнөх жилээс 6.0 пунктээр нэмэгдсэн байна.

Их, дээд сургууль, коллежид шинээр элсэгчид, дүнд эзлэх хувь



2021-2022 оны хичээлийн жилд шинээр элсэгчдийн дотор тухайн жилд 12 дугаар анги төгсөгчдөөс элсэгчид 25.2 (82.6%) мянга байгаа бол тухайн жилд техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшигчдээс элсэгчид 0.4 (1.4%) мянга байна.

- Тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшигчдээс
- Тухайн жилд техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшигчдээс
- Тухайн жилд бакалаврын боловсрол эзэмшигчдээс
- Ажиллагчдаас
- Ажилгүй иргэдээс
- Бусад



3. ДОТУУР БАЙР


Дотуур байранд амьдарч буй суралцагчдын тоо



2021-2022 оны хичээлийн жилд 7,084 суралцагч дотуур байранд суухаар хүсэлт гаргасны 7,027 нь дотуур байраар хангагджээ. Дотуур байранд амьдарч байгаа суралцагчдын 6,446 (91.7%) нь өөрийн сургуулийн, 667 (8.3%) нь бусад сургуулийн дотуур байранд амьдарч байгаа бол дотуур байранд амьдардаг бакалаврын түвшний суралцагчийн эзлэх хувь 88.4%, үүнээс 1-р дамжаанд суралцагчийн эзлэх хувь 42.2% байна.


4. ТӨГСӨГЧИД

Нийт төгсөгчид, хүйсээр



Их, дээд сургууль, коллежийг 2020-2021 оны хичээлийн жилд 31,161 төгсөгч төгсөж өмнөх оны хичээлийн жилээс 3,116 (11.1 %) -аар өссөн байгаа ба нийт төгсөгчдийн 19,861 (63.7%) нь эмэгтэйчүүд байна.

Нийт төгсөгчид, боловсролын зэргээр




Нийт төгсөгчдийг боловсролын зэргээр авч үзвэл, 2020-2021 оны хичээлийн жилд 25.8 мянга нь бакалавр болон дипломын дээд, 5.3 мянга нь магистр, 44 нь докторын зэрэг эзэмшсэн байна.

Бакалаврын зэргээр төгсөгчдөд дипломын дээд боловсролын зэргээр төгсөгчдийг оруулсан.



Дээд боловсролын сургалтын байгууллагын нийт төгсөгчдийн тоо, мэргэжлийн ерөнхий чиглэлээр



Дээд боловсролын сургалтын байгууллагын нийт төгсөгчдийн тоо, хүйс, мэргэжлийн ерөнхий чиглэлээр, дүнд эзлэх хувь



Дээд боловсролын сургалтын байгууллагыг 2020-2021 оны хичээлийн жилд нийт 31.2 мянган оюутан төгссөний 19.9 (63.7%) мянга нь эмэгтэй, 11.3 (36.3%) мянга нь эрэгтэй байна. Нийт төгсөгчдийн хамгийн их нь буюу 9.8 (31.4%) мянга нь бизнес, удирдахуй, хууль, эрх зүйн мэргэжлээр төгссөн байгаа бол хамгийн бага нь буюу 407 (1.3%) нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлэг мэргэжлээр төгссөн байна. Мэдээлэл, харилцааны технологи, инженер, үйлдвэрлэл, барилга угсралт, хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлэг болон үйлчилгээний чиглэлээр эрэгтэйчүүд илүү төгссөн бол бусад мэргэжлээр эмэгтэйчүүд илүү төгссөн байна.


5. ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ, АЖИЛЛАГЧИД

Дэд боловсролын сургалтын байгууллагад ажиллагчид, үндсэн багш, хүйсээр

Дэд боловсролын сургалтын байгууллагад ажиллагчид	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022
Ажиллагчдын тоо	12,634	11,306	11,970	12,175
Эмэгтэй	7,912	7,061	7,505	7,688
Эрэгтэй	4,722	4,245	4,465	4,487
Үндсэн багшийн тоо	6,669	7,315	7,143	6,102
Эмэгтэй	4,028	4,482	4,314	3,740
Эрэгтэй	2,641	2,833	2,829	2,362
Нийт ажиллагчдад үндсэн багшийн эзлэх хувь	52.8	64.7	59.7	50.1

Их, дээд сургууль, коллежийн ажиллагчдын тоо 2021-2022 оны хичээлийн жилд 12,175 болж өмнөх оны хичээлийн жилээс 205 (1.7%)-аар өссөн байна. 2021-2022 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллагчдын 7,688 (63.1%) нь эмэгтэй, 4,487 (36.9%) нь эрэгтэй байна.

Дэд боловсролын сургалтын байгууллагад ажиллагчид, үндсэн багш, өмчийн хэлбэрээр, 2021-2022 оны хичээлийн жилд



Өмчийн хэлбэрээр харахад, 2021-2022 оны хичээлийн жилд ажиллаж байгаа нийт ажиллагчдын 7,620 (62.6%) нь төрийн өмчийн сургуульд, 4,283 (35.2%) нь хувийн өмчийн сургуульд, 272 (2.2%) нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд ажиллаж байна.

Өмчийн хэлбэрээр харахад, 2021-2022 оны хичээлийн жилд ажиллаж байгаа нийт үндсэн багшийн 3,769 (61.8%) нь төрийн өмчийн сургуульд, 2,170 (35.6%) нь хувийн өмчийн сургуульд, 163 (2.7%) нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд ажиллаж байна.



Их, дээд сургууль, коллежид ажиллаж буй үндсэн багшийн тоо 2021-2022 оны хичээлийн жилд 6,102 болж өмнөх хичээлийн жилээс 1,041 (14.6%)-аар буурсан байна.



2021-2022 оны хичээлийн жилд нийт ажиллагчдын тоо өссөн хэдий ч үндсэн багш нарын тоо буурсан нь дараах шалтгаанаар тайлбарлагдаж байна: Үүнд:


- Сүүлийн 2 жилийн хугацаанд Ковид-19 цар тахлын онцгой нөхцөл байдлын улмаас хичээл сургалтын үйл ажиллагаа онлайн хэлбэрт шилжиж нэг үндсэн багшид ногдох цагийн ачаалал буурч, цагийн багшид шилжиж байна.
- Сүүлийн 2 жилд хэд хэдэн сургууль татан буугдаж, зарим сургуулийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа өргөжин тэлж, сургуулийн ангилалд өөрчлөлт орсонтой холбоотой байна.



Боловсролын түвшнээр авч үзвэл, докторын боловсролтой үндсэн багш 2,204 (36.1%), магистрын боловсролтой үндсэн багш 3,634 (59.5%) байна.



Дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн багшийн нас, хүйсийн суварга, дүнд эзлэх хувь




Нийт 6,102 үндсэн багш ажиллаж байгаагийн 3,740 (61.3%) нь эмэгтэй багш нар байна. Насны хувьд авч үзвэл, нийт үндсэн багшийн 434 нь 30 хүртэлх насны залуучууд, 1,013 нь 55-аас дээш насны ахмад багш нар ажиллаж байна.

Улсад ажилласан жилээр нь багш нарыг ангилж үзвэл: 45.4 хувь нь 1-5 жил, 5.6 хувь нь 25-аас дээш жил ажилласан ажлын дадлага туршлагатай багш нар эзэлж байна.

6. ТӨСВИЙН МЭДЭЭЛЭЛ

Дээд боловсролын нийт урсгал төсөв, тэрбум төгрөг




Боловсрол, шинжлэх ухааны салбарын нийт урсгал төсвийн 1.3 их наяд төгрөгийн 30.6 тэрбум төгрөг буюу 2.2% нь дээд боловсролын салбарт зарцуулагдаж байна.

7. ЗАРИМ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛАЛТ


Дээд боловсролд суралцах хугацааг 2019 оны байдлаар авч үзвэл, Турк Улс 5.7 жил, Финланд 4.3 жил байгаа нь хамгийн өндөр байна. Харин хамгийн бага нь Бразил Улс 2.4 жил, Их Британи Улс 2.9 жил байна. Монгол Улсын хувьд дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа дундаж хугацаа нь 3.1 жил байна.

Дээд боловсролд суралцах дундаж хугацаа, жилээр, 2019 он



Эх үүсвэр: ЮНЕСКО-гийн Статистикийн институт

Дээд боловсролын нийт төгсөгчид, дүнд эзлэх хувиар, мэргэжлийн чиглэлээр, улсаар, 2019 он



Эх үүсвэр: Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын боловсролын тайлан



Олон улсын түвшинд авч үзвэл, дээд боловсролын нийт төгсөгчдийн дийлэнх хувь нь санхүү, бизнесийн удирдлагын чиглэлээр төгссөн байна. Тухайлбал, Бразил Улсад 35.6 хувь нь, Турк Улсад 34.6 хувь нь, ОХУ-д 33.1 хувь нь, Монгол Улсад 24.9 хувь нь, ХБНГУ-д 23.4 хувь нь, Их Британид 22.0 хувь нь энэ чиглэлээр төгссөн байна.

Дээд боловсролд суралцаж буй гадаад оюутан, дүнд эзлэх хувиар, улсаар, 2019 он



Их Британи Улсын дээд боловсролын нийт суралцагчдын 17.9 хувь нь Австри Улсын 17.2 хувь нь, Нидерланд Улсын 11.0 хувь нь гадаад оюутан байгаа бол Монгол Улсын нийт суралцагчдын 1.0 хувь нь, Мексик, Бразил, Колумби, Индонез Улсуудад 1 хүрэхгүй хувийг гадаад оюутнууд эзэлж байна.


Эх үүсвэр: ЮНЕСКО-гийн Статистикийн институт



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ
ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

БАГШИИН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ

Багшийн хөгжлийг дэмжих сургалтын тоо, төрлөөр, түүнд хамрагдагчид,
2016-2021 он





Их, дээд сургуулийн багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр хийсэн ажил, 2021 он

<p>ЦАХИМ СУРГАЛТ (2021 ОНЫ 1-4 САР)</p>	<ol style="list-style-type: none"> 1. “Багшлахуйгаас суралцахуйд шилжих шилжилтийг хурдасгах нь” 2. “21-р зууны дижитал технологи ба их сургуулийн багш”
<p>ХЭЛЭЛЦҮҮЛЭГ (2021 ОНЫ 1-4 САР)</p>	<ol style="list-style-type: none"> 1. “Дээд боловсролын багшийн хөгжлийн албаны ажлын чиглэл төлөвлөгөө” 2. “Ментор ба ментий” 3. “Харилцааны ур чадвар зөөлөн чадварын суурь болох нь”
<p>МОДЕЛЬ СУРГАЛТ (2021-2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ)</p>	<ol style="list-style-type: none"> 1. “Боловсролын хөтөлбөрийг загварчлах, шинэчлэх нь” 2. “Багшийн судалгааны чадавхийг хөгжүүлэх нь” 3. “Хүн төвтэй өөрчлөлтийн менежмент” 4. “Багшлахуйгаас суралцахуйд шилжих шилжилтийг хурдасгах нь”

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН

Эрдэм шинжилгээний ажлын тоо



Судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийн тоо



БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САН

Боловсролын зээлийн сангаар хэрэгждэг хөтөлбөр




Боловсролын зээлийн сангаас 2015-2021 оны хооронд олгосон санхүүжилт:

	Оюутны хөгжлийн зээл	Буцалтгүй тусламж	ЗГ-ын гэрээгээр гадаадаас Монголд	Гадаад зээл - Бакалавр	Гадаад зээл - Магистр, доктор	Гадаад зээл - Тэтгэлэг
Оюутны тоо	11,063	4,135	154	91	45	117
Санхүүжилт /тэрбум төгрөг/	17.4	6.3	351.1 сая	6.3	2.6	1.6

Сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлээр суралцагчид /1993-2016 он/

1993	1994	1995	1996	1997
80,035 суралцагч 290.1 сая	8,115 суралцагч 395.3 сая	6,033 суралцагч 407.5 сая	6,872 суралцагч 478.3 сая	6,128 суралцагч 737.1 сая
2002	2001	2000	1999	1998
9,236 суралцагч 1.7 Тэрбум	9,908 суралцагч 2.5 Тэрбум	9,856 суралцагч 2.4 Тэрбум	9,441 суралцагч 2.3 Тэрбум	8,050 суралцагч 1.5 Тэрбум
2003	2004	2005	2006	2007
8,409 суралцагч 2.1 Тэрбум	9,494 суралцагч 2.2 Тэрбум	8,696 суралцагч 2.2 Тэрбум	8,460 суралцагч 2.1 Тэрбум	7,782 суралцагч 1.9 Тэрбум
2012	2011	2010	2009	2008
3,381 суралцагч 783.8 сая	6,013 суралцагч 1.04 Тэрбум	7,280 суралцагч 3.2 Тэрбум	7,319 суралцагч 3.1 Тэрбум	7,048 суралцагч 2.8 Тэрбум
2013	2014	2015	2016	НИЙТ
5,849 суралцагч 1.6 Тэрбум	4,421 суралцагч 1.4 Тэрбум	1,985 суралцагч 1.5 Тэрбум	1,830 суралцагч 568.3 сая	169,641 суралцагч 39.2 Тэрбум

Оюутны хөгжлийн зээл, 2018-2021 он



Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэгээр суралцагчид, 1995-2021

1995	1996	1997	1998	1999
125 суралцагч 1.3 сая	326 суралцагч 22.7 сая	581 суралцагч 69.8 сая	965 суралцагч 184.4 сая	1,140 суралцагч 272.7 сая
2004	2003	2002	2001	2000
20,076 суралцагч 5.4 Тэрбум	15,940 суралцагч 3.7 Тэрбум	11,057 суралцагч 2.8 Тэрбум	6,562 суралцагч 1.7 Тэрбум	3,489 суралцагч 1.1 Тэрбум
2005	2006	2007	2008	2009
20,879 суралцагч 6.3 Тэрбум	20,421 суралцагч 5.6 Тэрбум	19,143 суралцагч 5.3 Тэрбум	17,240 суралцагч 6.5 Тэрбум	16,913 суралцагч 8.2 Тэрбум
2014	2013	2012	2011	2010
5,088 суралцагч 6.9 Тэрбум	8,840 суралцагч 3.2 Тэрбум	3,462 суралцагч 2.5 Тэрбум	15,801 суралцагч 3.19 Тэрбум	17,267 суралцагч 8.8 Тэрбум
2015	2016	2017	2018	2019
5,273 суралцагч 7.1 Тэрбум	5,415 суралцагч 6.99 Тэрбум	5,830 суралцагч 12.8 Тэрбум	6,070 суралцагч 12.4 Тэрбум	6,538 суралцагч 11.6 Тэрбум
НИЙТ		2021	2020	
243,243 суралцагч 132.8 Тэрбум		4,135 суралцагч 6.3 Тэрбум	4,667 суралцагч 3.1 Тэрбум	

Гадаад дотоодын зээл, тэтгэлэгт хамрагдсан суралцагчдын тоо




НИЙТ: **1,419,140 мянган** - суралцагчдад /Давхардсан тоо/
909.8 тэрбум - төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

1995-2020 онд хөнгөлөлттэй зээлээр суралцагчдын дипломын бүртгэл




НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Насан туршийн боловсролын үндсэн сургалтын тоо ба түүнд хамрагдсан иргэдийн тоо, 2017-2021




Насан туршийн боловсролын үндсэн сургалтад хамрагдсан иргэдийн тоо, сургалтын чиглэлээр, 2017-2021



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИИ ЗӨВЛӨЛ

Магадлан итгэмжлэлийн хугацаа хүчинтэй дээд боловсролын сургалтын байгууллага, ангиллаар, 2021 он



Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын магадлан итгэмжлэл



Монгол Улсын хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөрүүд


»» Монгол Улсын хэмжээнд 88 их, дээд сургууль 3,361 хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагаа явуулж байна



Магадлан итгэмжилсэн хөтөлбөрийн тоо, сургуулийн өмчийн хэлбэрээр, 2018-2021



Магадлан итгэмжилсэн хөтөлбөрийн тоо, боловсролын түвшнээр, 2018-2021




Урьдчилсан магадлан итгэмжлэл буюу шинэ хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, 2017-2021 он



Он	Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо	Төрийн өмчийн сургууль	Төрийн бус өмчийн сургууль	Бакалавр	Магистр	Доктор	Диплом
2017	42	15	27	27	14	1	
2018	42	13	29	23	8	11	
2019	31	7	24	15	14	2	
2020	29	6	23	18	9	2	
2021	37	18	19	24	9	3	1
Бүгд	181	59	122	107	54	19	1

ОЛОН УЛСЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

Олон улсад магадлан итгэмжлэгдсэн 110 хөтөлбөр байна.



Тайлбар:
D - Бакалаврын хөтөлбөр
E - Магистрын хөтөлбөр

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

Үйл ажиллагааны чиглэл



Элсэлтийн ерөнхий шалгалт

Боловсролын үнэлгээний төв нь 2006 оноос хойш улсын хэмжээнд их, дээд сургуульд элсэгчдийн сурах ерөнхий чадвар, мэдлэгийн түвшинг тогтоох зорилго бүхий Элсэлтийн ерөнхий шалгалтыг дараах циклийн дагуу зохион байгуулж байна.



ӨГӨГДЛИЙН САНГИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

ЕБС
839
ГАРУЙ


БАГШИЙН
МЭДЭЭЛЭЛ
32.000
ДАВХАРДСАН ТОО

ЭШ-Д
ШАЛГУУЛАГЧДИЙН ТОО
525.000
ГАРУЙ

ДҮНГИЙН
МЭДЭЭЛЭЛ
1.665.000
ГАРУЙ

ХАРИУЛТЫН ХУУДАСНЫ
МЭДЭЭЛЭЛ
151.848.000
ГАРУЙ

2017-2021 ОНЫ ЭЭШ-ЫН АНХНЫ ОНООГ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН



ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТЫН СТАТИСТИК ТАЙЛАНГИЙН СИСТЕМ /www.stat.eec.mn/

ШАЛГУУЛАГЧДЫН СТАТИСТИК

- Бүртгэгчид болон шалгуулагчдын статистик
- Хичээл сонголтын шалгуулагч
- Хичээл сонголтын тоо дүгнэлээр

ШАЛГАЛТЫН ЕРӨНХИЙ СТАТИСТИК

- Улс, бүсийн ерөнхий үр дүн
- Газар зүйн байршил
- Сургуулийн байршил
- Сургуулийн өмчийн хэлбэр
- Суралцагчийн хэв шинж
- Хүйсээр
- Аймаг, дүүргийн дундаж
- Хичээл тус бүрийн дүн

ДААЛГАВРЫН СТАТИСТИК

- Агуулга тус бүрийн тоон шинжилгээ
- Дэл агуулга тус бүрийн тоон шинжилгээ
- Танин мээлзүйн түвшинд хийсэн тоон шинжилгээ
- Даалгаврын хэлбэр
- Даалгавар тус бүрийн тоон шинжилгээ

СИСТЕМИЙН ХЭРЭГЛЭГЧИД

- БУТ
- БШУЯ
- БМЦН, БХ
- БСУТ, НБГ
- ДҮҮРГИЙН БХ
- ЕБС-ИЙН УДИРДАХ АЖИЛТАН
- БАГШ
- СУДЛААЧИД

HELP.EEC.MN /цахим зөвлөх/




МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН ШАЛГАЛТ

- ШУА-ын Хэл зохиолын хүрээлэнтэй зөвшилцөн тогтоосон.
- Шалгуулагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг сориход чиглэсэн.
- Нийт 50 оноотой. Шалгалтын үргэлжлэх хугацаа 100 минут.

ШАЛГАЛТЫН АГУУЛГА	01 УНШААД ОЙЛГОХ ЧАДВАР	- Ойролцоогоор 700 орчим үгтэй бүрэн хэмжээний орчуулгын бус эх байна. - Сонгох хэлбэрийн 10 даалгавар гүйцэтгэнэ. - НИЙТ 20 ОНОО
	02 ЗӨВ БИЧИХ ЧАДВАР	- Бичил эхээс алдаатай бичсэн 5 үгийг олж зөв бичгийн дүрмээр залруулна. - НИЙТ 5 ОНОО.
	03 МОНГОЛ БИЧГЭЭР УНШИХ ЧАДВАР	- Монгол бичгээр бичсэн 40 орчим үгтэй бичил эхийг хөрвүүлнэ. - НИЙТ 5 ОНОО
	04 ЭХ ЗОХИОН НАЙРУУЛАХ ЧАДВАР	- 350 орчим үгтэй эхийг хэнд зориулж, ямар зорилгоор, ямар хэлбэрээр бичихийг заасан. - НИЙТ 20 ОНОО. - Эх зохион найруулах чадварыг доорх 9 үзүүлэлтээр шалгаж байгаа.



МОНГОЛ ХЭЛ. БИЧГИЙН ШАЛГАЛТЫН ҮР ДҮН



БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГАА

СУДАЛГААНД ХАМРАГДСАН СУРГУУЛЬ /ТҮҮВЭР/




Боловсролын чанарын үнэлгээ нь суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг үндэсний түвшинд тогтоох, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд чиглэнэ.



БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН



ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ СТАТИСТИК ТАЙЛАНГИЙН СИСТЕМ /www.ch.stat.eec.mn/



ХИЧЭЭЛ СУРГАЛТЫН ХОЦРОГДЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ
ОНОШЛОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ
/2021.09.23-24/



БАГА

- Математик
- Монгол хэл
- Хүн ба байгаль

II-XII
АНГИ



755

нийт
СУРГУУЛЬ

СУУРЬ

- Математик
- Монгол хэл
- Байгалийн ухаан
- Нийгмийн ухаан

БҮРЭН ДУНД

- Математик
- Монгол хэл
- Англи хэл
- Сонгон судлах – 6 хичээл



62856


НЭГЖ СУРАГЧИЙН
ТООГООР



297599

ДАВХАРДСАН
ТООГООР

ОНОШЛОХ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮН, АНГИАР



ОНОШЛОХ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮН, СУДЛАГДАХУУНААР



ХОЦРОГДОЛТОЙ СУРАЛЦАХУЙН ЗОРИЛТЫН МЭДЭЭЛЭЛ

	Судлагдахууны тоо	Суралцахуйн зорилтын тоо	Бага	Суурь	Бүрэн дунд
Сургалтын хөтөлбөрт 	152	3692	787	1543	1362
Оношлох үнэлгээнд 	64	2133	323	1022	788
Судалгааны үр өгнө 	64	515	35	217	262

СУРЛАГЫН АМЖИЛТАД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН АСУУЛГА СУДАЛГААНЫ ХҮРЭЭ



2021 ОНЫ СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТОО



ХОЦРОГДОЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС




СУРГУУЛЬД БЭЛТГЭГДСЭН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ СУДАЛГАА

Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний "ДААЛГАВРЫН САН" ашиглалтад оруулсан.

www.subitems.eec.mn

/суралцахуйн 6 чиглэлээр нийт 753 даалгавар/



ХАМРАХ ХҮРЭЭ



323
НИЙТ
СУРГУУЛЬ



1354
НИЙТ
БҮЛЭГ



4062
НИЙТ
БАГШ



23462
НИЙТ СУРАГЧ


ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛ ТУС БҮРИЙН ҮР ДҮН

65% | Нийгэмшихүйн хөгжил

56% | Бие бялдарын хөгжил

61% | Танин мэдэхүйн хөгжил

СУРАЛЦАХУЙН ЧИГЛЭЛ ТУС БҮРИЙН ҮР ДҮН



Хянасан:

Ю.АЛТАНТУЯА БШУЯ-ны Цахим бодлого, статистикийн хэлтсийн дарга

С.ТОДГЭРЭЛ ҮСХ-ны НСГ-ын Нийгмийн статистикийн хэлтсийн дарга

Боловсруулсан:

Д.АНХЗАЯА БШУЯ-ны Цахим бодлого, статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Хамтран ажилласан:

З.ЭНХЖАРГАЛ БМТТ-ийн бизнесийн шинжилгээний мэргэжилтэн

Э.ДОЛГОРМАА БМТТ-ийн бизнесийн шинжилгээний мэргэжилтэн

Эх бэлтгэл:

Б.МӨНГӨНШАГАЙ БМТТ-ийн Судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дизайнер

Хаяг:

Засгийн газрын III байр, Бага тойруу -44, Улаанбаатар -11 Монгол Улс

Цахим хаяг: <https://meds.gov.mn/>

И-мэйл: Info@mecs.gov.mn, ankhzaya@mecs.gov.mn

Утас: 11-318131

